Төрөл бүрийн материал ашиглан хөгжмийн энгийн зэмсэг бүтээж, байгалийн дуу чимээ үүсгэж үзүүлдэг.	Бөмбөр, шагшуур, шигшүүр зэрэг хөгжмийн энгийн зэмсгийг янз бүрийн материал ашиглан хийдэг.	Хөгжмийн энгийн зэмсэг тус бүрийн тоглох аргыг үзүүлдэг, тайлбарладаг.	Хөгжмийн энгийн зэмсгийн дуугаралтын ялгааг тайлбарладаг.	Өөрийн бүтээсэн хөгжмийн зэмсгээрээ байгалийн дуу чимээг дүрслэн илэрхийлж хамтран тоглодог.

1.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 2. ХЭМ, ХЭМЖЭЭ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1.2а. Хялбар дуу, аялгууг сонсож, хэмжээ хэмнэлийг тодорхойлох, жишээгээр харуулах	Сурагч дуу болон аялгуунаас айзам хэмжээг мэдэрч илэрхийлж чаддаг болно.
1.2б. Өөрийгөө болон бусдыг сонсож хэмжээ хэмнэлд нийцүүлэн дууны үгийг тод, зөв хуваарилж хамтран дуулах	Сурагч эгшгийн уртаашийг ялган таньж айзмын хувийг илэрхийлж чадахаа харуулна.
1.2в. Эгшгийн уртаашийг (дөрөвт, наймт) ялган таних, дүрсээр тэмдэглэх, хөгжмийн энгийн зэмсэг ашиглан 2 хувьт хэмд хэмнэлээр дагаж хөгжимдөх	Сурагч дуулахдаа айзам хэмжээ, хөгжмийн хамсраа болон бусадтай нийцэж чадахаа харуулна.
1.2г. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, хүчтэй сул хувийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулж харуулах	Сурагч 2 ба 3 хувьт хэмд дуулж, энгийн зэмсгээр хамсран хөгжимдөж чадахаа харуулна.
1.2д. Хоёр хувиар хэмнэл зохиосноо хөгжмийн энгийн зэмсгээр хөгжимдөж харуулах	Сурагч аялгууны шинж төрх, айзам хэмжээнд тохирох хөдөлгөөнийг хамтран гүйцэтгэж чаддаг болно.

1.2.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч дуу болон аялгуунаас айзам хэмжээг мэдэрч илэрхийлж чаддаг болно.	Хялбар дуу, аялгууг сонсоод айзам хэмжээг тодорхойлдог.
2	Сурагч эгшгийн уртаашийг ялган таньж айзамын хувийг илэрхийлж чадахаа харуулна.	Эгшгийн уртаашийг (дөрөвт, наймт) ялган таньж, дүрсээр тэмдэглэж чаддаг.

3	Дуулахдаа айзам хэмжээ, хөгжмийн хамсраа болон бусадтай нийцэж чадахаа харуулна.	Дуулахдаа өөрийгөө болон бусдыг сонсож, хэмжээ хэмнэлд нийцүүлэн хамтран дуулдаг.
4	Сурагч 2 ба 3 хувьт хэмд дуулж, энгийн зэмсгээр хамсран хөгжимдөж чадахаа харуулна.	2 ба 3 хувьт айзмыг ялган таньж, энгийн зэмсэг ашиглан хэмнэлээр хөгжимддөг.
5	Сурагч аялгууны шинж төрх, айзам хэмжээнд тохирох хөдөлгөөнийг хамтран гүйцэтгэж чаддаг болно.	Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, айзам хэмжээг мэдэрч тохирох хөдөлгөөнөөр илэрхийлдэг.

1.2.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Хялбар дуу, аялгууг сонсоод айзам хэмжээг тодорхойлдог.	Хялбар дуу аялгууг сонсоод айзам хэмжээг ялган таньж тодорхойлдог.	Хялбар дуу дасгалын айзам хэмжээг мэдэрснээ алга ташилтаар илэрхийлдэг.	Сонссон дуу аялгууны айзам хэмжээг зураглалаар илэрхийлдэг.	Хялбар дуу аялгуу сонсоод айзмын ялгааг тайлбарладаг, жишээгээр харуулдаг.
Эгшгийн уртаашийг (дөрөвт, наймт) ялган таньж, дүрсээр тэмдэглэж чаддаг.	Эгшгийн уртаашийг (дөрөвт, наймт) таньдаг, ялгаж нэрлэдэг	Эгшгийн уртаашийг (дөрөвт, наймт) дүрсээр тэмдэглэдэг.	Эгшгийн уртаашийг (дөрөвт, наймт) үг хэллэгтэй холбон хэмнэлжүүлдэг.	Эгшгийн уртаашийг (дөрөвт, наймт) илэрхийлсэн тэмдэглэгээг уншиж алга ташилтаар болон энгийн хөгжмийн зэмсэг ашиглан илэрхийлдэг.
Дуулахдаа өөрийгөө болон бусдыг сонсож, хэмжээ хэмнэлд нийцүүлэн хамтран дуулдаг.	Дуулах дууныхаа айзам хэмжээг мэдэрч, зэрэг эхэлж, төгсгөдөг.	Удирдаач багшийн дохиог ойлгож айзамд нийцүүлэн хамтран дуулдаг.	Дуулахдаа бусдыгаа сонсож, нийцүүлдэг.	Гоцлож болон хамтран дуулахдаа сэтгэл хөдлөлөө илэрхийлдэг.
2 ба 3 хувьт айзмыг ялган таньж, энгийн зэмсэг ашиглан хэмнэлээр хөгжимддөг.	2 ба 3 хувьт айзмыг дүрсээр болон ноот бичвэрээр тэмдэглэдэг.	2 ба 3 хувьт айзмын ялгааг гаргаж алга ташилтаар илэрхийлдэг.	2 ба 3 хувийг үг хэллэгтэй холбон илэрхийлдэг.	2 ба 3 хувьт айзмыг энгийн зэмсэг ашиглан илэрхийлдэг.
Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, айзам хэмжээг мэдэрч тохирох хөдөлгөөнөөр илэрхийлдэг.	Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, айзам хэмжээг тодорхойлдог.	Хөгжмийн айзам хэмжээг мэдэрч хөгжимт хөдөлгөөнөөр илэрхийлдэг.	Сонссон зохиолынхоо айзам хэмжээ, аялгууны шинж төрх, эгшиглэлтийн хүчид тохируулан хөдөлгөөнөө зохицуулдаг.	Хөгжмийн зохиолыг сонсоод сэтгэл хөдлөл, мэдрэмжээ илэрхийлсэн янз бүрийн хөдөлгөөн туршдаг.

1.3. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 3. ЭНГИЙН ХЭМНЭЛ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1.3а. Хөгжмийн төрөл зүйл /дуу, бүжиг, марш/-ийг сонсож тодорхойлох, сэтгэгдэлээ илэрхийлэх	Сурагч хөгжмийн аялгуунаас айзам хэмжээ, шинж төрхийг мэдэрч сэтгэгдэлээ илэрхийлж чаддаг болно.
1.3б. Сонсголын тогтоолт дээр тулгуурлан 2 ба 3 хувьт хэмд хэмжээ хэмнэлээ нийлүүлэн нэгэн зэрэг дуулж чадахаа харуулах	Сурагч хэмжээ, хэмнэлд нийцүүлэн үгийг тод хэлж дуулж чадахаа харуулна.
1.3в. Хоёр ба гурван хувьт хэмд сонсголын тогтоолт дээр тулгуурлан бие даан ноотоор хөгжимдөж гүйцэтгэх	Сурагч 2 ба 3 хувьт хэмд энгийн хэмнэлийг ноотоор хөгжимдөж чаддаг болно.
1.3г. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг тодорхойлж, тохирох дүрийг (цэцэг, амьтад...) хөдөлгөөнөөр илэрхийлэх	Сурагч аялгууны шинж төрх болон хэмнэлд тохируулан хөгжимт хөдөлгөөн хийж чаддаг болно.
1.3д. Янз бүрийн хэмнэлээр тодорхой сэдэвт зохиомж хийж/морьд, бороо, марш, бүүвэй.../ үзүүлэх	Сурагч 2 ба 3 хувьт хэмнэлийг дүрсэлж чаддаг болно.

1.3.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Хөгжмийн аялгуунаас айзам хэмжээ, шинж төрхийг мэдэрч сэтгэгдэлээ илэрхийлж чаддаг болно.	Хөгжмийн зохиол (дуу, бүжиг, марш)-ыг сонсоод шинж төрх, айзмыг ялган таньдаг, төрсөн сэтгэгдэлээ илэрхийлдэг.
2	Хэмжээ, хэмнэлд нийцүүлэн үгийг тод хэлж дуулж чадахаа харуулна.	2 ба 3 хувьт айзамд нийцүүлэн бусадтай хамтран дуулж чадахаа харуулдаг.
3	2 ба 3 хувьт хэмд энгийн хэмнэлийг ноотоор хөгжимдөж чаддаг болно.	2 ба 3 хувьт айзамд хэмнэлийн зураглалыг энгийн зэмсэг ашиглан хөгжимдөж чаддаг.
4	Сурагч аялгууны шинж төрх болон хэмнэлд тохируулан хөгжимт хөдөлгөөн хийж чаддаг болно.	Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, айзамд нийцүүлэн тохирох дүр (цэцэг, навч, салхи, амьтад...)-ийг хөдөлгөөнөөр илэрхийлж чаддаг.
5	Сурагч 2 ба 3 хувьт хэмнэлийг дүрсэлж чаддаг болно.	Тодорхой сэдвээр 2 ба 3 хувьт хэмнэлийг дүрсэлж үзүүлдэг.

1.3.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Хөгжмийн зохиол (дуу, бүжиг, марш)-ыг сонсоод шинж төрх, айзмыг ялган таньдаг, төрсөн сэтгэгдэлээ илэрхийлдэг.	Дуу, бүжиг, маршийг сонсоод айзам хэмжээг ялган таньдаг.	Дуу, бүжиг, маршийн хэмнэлийг зураглаж чаддаг.	Дуу, бүжиг, маршийн шинж төрх, айзмын ялгааг тайлбарлаж чаддаг.	Дуу, бүжиг, маршийг сонсоод төрсөн сэтгэгдэлээ зурж, хэмнэлжүүлж, бичиж илэрхийлдэг.
2 ба 3 хувьт айзамд нийцүүлэн бусадтай хамтран дуулж чадахаа харуулдаг.	Дуу, дасгалыг айзам хэмжээнд нийцүүлэн дуулдаг.	Дуулахдаа 2-3 үетэй үгийг тод дуудаж зөв хуваарилж дуулдаг.	Дуулахад биеийн байрлал, амьсгаа чухал болохыг мэддэг, харуулж чаддаг.	2 ба 3 хувьт айзамд гоцлол болон найрлаар бусадтай нийцэж дуулж чадахаа харуулдаг.

2 ба 3 хувьт айзамд хэмнэлийн зураглалыг энгийн зэмсэг ашиглан хөгжимдөж чаддаг.	Дуу, дасгалын айзам хэмжээг тодорхойлж, илэрхийлж чаддаг.	2 ба 3 хувьт хэмд бичигдсэн хялбар дуу, дасгалын хэмнэлийн зураглалыг ажиглаад, хэмжээ хэмнэлээ нийлүүлэн хөгжимддөг.	Удирдаач багшийн дохиог мэдэрч хэмнэлээр хамтран хөгжимддөг.	Дуу болон сонссон хөгжимдөө хэмнэлийн хамсраа хийдэг.
Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, айзамд нийцүүлэн тохирох дүр (цэцэг, навч, салхи, амьтад...)-ийг хөдөлгөөнөөр илэрхийлж чаддаг.	Сонгосон хөгжмийн аялгууны шинж төрхийг тодорхойлж тохирох хөдөлгөөн хийдэг.	Аялгууны шинж төрхөд тохирох дүрийн талаар ярилцаж, тохиромжтой хөдөлгөөнийг үзүүлж чаддаг.	Сонгосон дүрдээ тохирох хөдөлгөөнийг сэтгэл хөдлөлтэйгээр илэрхийлж чаддаг.	Аялгууны шинж төрх, айзам хэмжээг мэдэрч хөдөлгөөнөө бусадтай нийцүүлэн илэрхийлж чаддаг.
Тодорхой сэдвээр 2 ба 3 хувьт хэмнэл зохиож үзүүлдэг.	Шинж төрх заасан үгийн тусламжтайгаар (чанга сул, хурдан удаан, хүнд хөнгөн цоглог гэх мэт) морьд, бороо, марш, бүүвэйн дүр бүтээж чаддаг.	Бусадтайгаа хамтран дүр бүтээж тоглох, бие даан хийж гүйцэтгэдэг.	Хөгжмийг сонсоод дүрийн шинж төрхөд тохируулан хөдөлгөөн хийж чаддаг.	Өгөгдсөн сэдвийг янз бүрийн хэмнэл, хөдөлгөөнөөр өөрийнхөөрөө баяжуулан үзүүлдэг.

1.4. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 4. АЯЛГУУНЫ ХЭМ, ХЭМНЭЛ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1.4а. Хөгжмийн төрөл зүйл /дуу, бүжиг, марш/-ийг сонсож хэмнэл, аялгууны шинж төрхийг тодорхойлох	Сурагч хөгжмийн бүтээлийг сонсоод төрөл зүйлийг ялгаж чаддаг болно.
1.4б. Дууны утга агуулгыг ойлгож, сэтгэл хөдлөлөө илэрхийлэн, гоцлол, найрлаар хөг нийлүүлэн дуулж чадахаа харуулах	Сурагч сэтгэл хөдлөлөө илэрхийлэн дуулж чаддаг болно.
1.4в. Хоёр ба гурван хувьт хэмтэй дуу аялгуунд хэмнэлийн хамсраа хийж, хэмнэл хэмжээ нийлүүлэн хамтран хөгжимдөж чадахаа харуулах	Сурагч аялгууны шинж төрх, айзам хэмжээг тодорхойлж, хамсран хөгжимдөж чаддаг болно.
1.4г. Тойрон бүжиг, аялгуут тоглоом, хөгжимт хөдөлгөөн хийхдээ аялгууны шинж төрх, хэмжээ, хэмнэл, хурд, хүчийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулах, өөрийнхөөрөө баяжуулан илэрхийлэх	Сурагч аялгууны шинж төрхийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулан хамтран бүжиглэж чаддаг болно.
	Сурагч сонссон дуу хөгжимдөө энгийн зэмсэг ашиглан хэмнэлийн хамсраа хийж чаддаг болно.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

1.4.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч хөгжмийн бүтээлийг сонсоод төрөл зүйлийг ялгаж чаддаг болно.	Хөгжим сонсоод, айзам хэмжээ, аялгууны шинж төрхөд тулгуурлан дуу, бүжиг, маршийн төрөл зүйлийг тодорхойлж чаддаг.
2	Сурагч сэтгэл хөдлөлөө илэрхийлэн дуулж чаддаг болно.	Дууны утга агуулгыг ойлгож, гоцлол болон найрлаар сэтгэл хөдлөлтэйгээр дуулдаг.
3	Аялгууны шинж төрх, айзам хэмжээг тодорхойлж ноотоор хамсран хөгжимдөж чаддаг болно.	Хялбар дуу, дасгалын айзам хэмжээг тодорхойлж, шинж төрхийг илэрхийлэн хэмнэлээр хамтран хөгжимддөг.
4	Сурагч аялгууны шинж төрхийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулан хамтран бүжиглэж чаддаг болно.	Тойрон бүжиг, аялгуут тоглоом, хөгжимт хөдөлгөөн хийхдээ аялгууны шинж төрх, хэмжээ, хэмнэл, хурд, хүчийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулж, тохирох хөдөлгөөн зохиомжилдог.
5	Сонссон дуу хөгжимдөө энгийн зэмсэг ашиглан хэмнэлийн хамсраа хийж чаддаг болно.	Сонссон хөгжим, дуулсан дуундаа хэмнэлийн хамсраа хийж, өөрийнхөөрөө баяжуулан илэрхийлдэг.

1.4.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Хөгжим сонсоод, айзам хэмжээ, аялгууны шинж төрхөд тулгуурлан дуу, бүжиг, маршийн төрөл зүйлийг тодорхойлж чаддаг.	Хөгжим сонсоод дуу, бүжиг, маршийн аль нь болохыг тодорхойлж нэрлэдэг.	Хөгжмийн төрөл зүйл /дуу, бүжиг, марш/-ийг сонсож айзам хэмжээ, хэмнэлийг тодорхойлдог.	Зураг, загвар, өгөгдөл ашиглан төрөл зүйлийг тодорхойлж, шинж төрх, айзам хэмжээг илэрхийлдэг.	Хөгжим сонсоод төрөл зүйлийн ялгааг тайлбарладаг.
Дууны утга агуулгыг ойлгож, гоцлол болон найрлаар сэтгэл хөдлөлтэйгээр дуулдаг.	Дууны утга агуулгыг ойлгож, аялгууны хурдыг мэдэрч дуулдаг.	Дууны утга агуулгыг илэрхийлэн хэмжээ, хэмнэлийг мэдэрч дуулдаг.	Амьсгааг зөв хуваарилж, үгийг тод дуудаж, сэтгэл хөдлөлөө илэрхийлж дуулдаг.	Дууны утга агуулгыг ойлгож ганцаараа болон хамтаараа хөгжимтэй, хөгжимгүй дуулдаг.
Хялбар дуу, дасгалын айзам хэмжээг тодорхойлж, шинж төрхийг илэрхийлэн хэмнэлээр хамтран хөгжимддөг.	Аялгууны хэмнэлд тохируулан алга ташилтаар хамсраа хийдэг.	Хөгжмийн энгийн зэмсгээр аялгууны шинж төрхийг илэрхийлэн хэмнэлээр хөгжимддөг.	Дууны үгийг хэмнэлжүүлэн алга ташилтаар хамсрал зохиож хөгжимддөг.	Хөгжмийн энгийн зэмсгээр 2 ба 3 хувьт хэмд гоцлол, цөөхүүл найрлаар хөгжимддөг.

Тойрон бүжиг, аялгуут тоглоом, хөгжимт хөдөлгөөн хийхдээ аялгууны шинж төрх, хэмжээ, хэмнэл, хурд, хүчийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулдаг, өөрийнхөөрөө баяжуулан илэрхийлдэг.	Тойрон бүжиг, аялгуут тоглоом, хөгжимт хөдөлгөөний ялгааг ойлгож гүйцэтгэдэг.	Тойрон бүжиг, аялгуут тоглоом, хөгжимт хөдөлгөөний дүрслэл илэрхийллийг мэдэрч түүнд тохируулан гүйцэтгэдэг.	Хөгжимт дасгал, хөдөлгөөнийг өөрийнхөөрөө баяжуулж гүйцэтгэл сайтай хийж чаддаг.	Аялгууны шинж төрх, хэмжээ хэмнэлд тохируулан хөдөлгөөн зохиомжлон хийдэг.
Сонссон хөгжим, дуулсан дуундаа хэмнэлийн хамсраа хийж, тохирох хөдөлгөөн зохиомжилдог.	Хүүхдийн, ардын, сонгодог, орчин үеийн хөгжмийг сонсоод хэмнэлийг мэдэрч чаддаг.	Дуу, хөгжмөөс мэдэрсэн хэмнэлээ энгийн зэмсэг болон алга ташилтаар илэрхийлдэг.	Хөгжмийн хэмнэл, аялгууны шинж төрхийг хөдөлгөөнөөр илэрхийлдэг.	Энгийн зэмсгээр хэмнэлийн хамсраа хийдэг, аялгуунд тохирох хөдөлгөөн зохиомжилдог.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. II АНГИ

2. II АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

2.1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 1. ХӨГЖМИЙН ДУУ АВИА, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
2.1а. Хүний дуу хоолойн өнгө аясыг сонсож тодорхойлох, сэтгэлийн хөдөлгөөнтэй холбоотой өөрчлөгддөгийг жишээгээр харуулах	Сурагч өнгө аясыг ялган сонсож тодорхойлдог болно.
2.1б. Энгийн хэмнэлийг эгшгийн өндөр намтай холбон өндрийн зураглал, тулгуур дохиог харж дуулах	Сурагч өндрийн зураглал, тулгуур дохиогоор дуулдаг болно.
2.1в. Өгөгдсөн аялгуунд хөгжмийн энгийн зэмсгээр хэмнэлийн хамсраа зохион хөгжимдөх	Сурагч янз бүрийн аялгуунд хэмнэлийн хамсраа зохион хөгжимддөг болно.
2.1г. Хөгжмийн зохиолын айзам хэмжээг мэдэрч, хөгжимт хөдөлгөөнөөр гүйцэтгэх	Сурагч хөгжмийг сонсоод мэдэрч, хөгжимт хөдөлгөөнөөр илэрхийлдэг болно.

2.1.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч өнгө аясыг ялган сонсож тодорхойлдог болно.	Хүний дуу хоолойн өнгө аяс сэтгэлийн хөдөлгөөнтэй холбоотой өөрчлөгдөж байгааг жишээгээр харуулдаг.
2	Сурагч өндрийн зураглал, тулгуур дохиогоор дуулдаг болно.	Хялбар дуу, аялгууг өндрийн зураглал, тулгуур дохиогоор дуулж чаддаг.
3	Сурагч янз бүрийн аялгуунд хэмнэлийн хамсраа зохион хөгжимддөг болно.	Хөгжмийн энгийн зэмсгийн дуугаралтын ялгааг илэрхийлэн хэмнэлээр хөгжимддөг.
		Янз бүрийн аялгуунд хөгжмийн энгийн зэмсгээр хэмнэлийн хамсраа зохион хөгжимддөг.
4	Сурагч хөгжмийг сонсоод мэдэрч, хөгжимт хөдөлгөөнөөр илэрхийлдэг болно.	Хөгжмийн зохиолын айзам хэмжээ, аялгууны чиглэл хөдөлгөөнийг мэдэрч, хөгжимт хөдөлгөөнөөр илэрхийлдэг.

2.1.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Хүний дуу хоолойн өнгө аяс сэтгэлийн хөдөлгөөнтэй холбоотой өөрчлөгдөж байгааг жишээгээр харуулдаг.	Хүний дуу хоолойн өнгө аясыг сонсоод таньдаг, нэрлэдэг. Жишээ нь: аав, ээж, дүү найзаа олох	Хүний дуу хоолойн өнгө аяс сэтгэлийн хөдөлгөөнтэй холбоотой өөрчлөгдөж байгааг тайлбарладаг.	Хүний дуу хоолойн өнгө аяс сэтгэлийн хөдөлгөөнтэй холбоотой өөрчлөгдөж байгааг нүүрний хувирлаар дүрсэлж үзүүлдэг.	Хүний дуу хоолойн өөрчлөлтийг зураглалаар дүрсэлж үзүүлдэг.
Хялбар дуу, аялгууг өндрийн зураглал, тулгуур дохиогоор дуулж чаддаг.	Хялбар дуу, аялгууны эгшгийн өгсөх, уруудах дарааллын зүй тогтлыг олж чаддаг.	Хялбар дуу, аялгууны эгшгүүдийг давтах хөдөлгөөнөөр дуулдаг.	Хялбар дуу, аялгууны эгшгүүдийг өгсөх, уруудах хөдөлгөөнөөр дуулдаг.	Хялбар дуу, аялгууны өндрийн зураглал, тулгуур дохиог харж дуулдаг.

Хөгжмийн энгийн зэмсгийн дуугаралтын ялгааг илэрхийлэн хэмнэлээр хөгжимддөг.	Хөгжмийн энгийн зэмсгийг нэрлэж чаддаг.	Хөгжмийн энгийн зэмсгийн дуугаралтыг сонсоод ялган таньдаг.	Хөгжмийн энгийн зэмсгийн дуугаралтын онцлогийг илэрхийлж хөгжимддөг.	Янз бүрийн айзмыг энгийн зэмсэг ашиглан хөгжимдөж чаддаг.
Өгөгдсөн аялгуунд хөгжмийн энгийн зэмсгээр хэмнэлийн хамсраа зохион хөгжимддөг.	Өгөгдсөн аялгууны өндрийг зурагладаг.	Хялбар дуу, аялгуунд хэмнэлийн хамсраа хийж хөгжимддөг.	Дүрс, зураас ашиглан хэмнэл зохиож чаддаг.	Энгийн хэмнэлийг өөрийнхөөрөө баяжуулан тоглодог.
Хөгжмийн зохиолын айзам хэмжээ, аялгууны чиглэл хөдөлгөөнийг мэдэрч, хөгжимт хөдөлгөөнөөр илэрхийлдэг.	Хөгжмийн зохиолын айзам хэмжээг мэдэрч хөдөлгөөнөөр илэрхийлж, дүрд хувирч тоглодог.	Дүрс бичлэгийг үзээд хөдөлгөөнийг дуурайж хийдэг.	Янз бүрийн хэрэгсэл ашиглан хөдөлгөөнийг гүйцэтгэдэг.	Хөгжмийн зохиолын хэмнэл, хурд, хүч, утга санааг хөдөлгөөнөөр илэрхийлдэг.

2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 2. ХӨГЖМИЙН ЭГШИГ ТЭМДЭГЛЭГЭЭ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
2.2а. Эгшгийн өндөр намыг ялган сонсож, хөгжмийн дүрийг тодорхойлоход ашиглах	Сурагч хөгжмийн дүрийг тодорхойлж чаддаг болно.
2.2б. G1-C2 эгшгийг дэвсгэр шугамд байрлуулж, ноотоор дуулах	Сурагч G1-C2 эгшгийг ноотоор дуулдаг болно.
2.2в. G1-C2 эгшгүүдээр давтах, өгсөх, уруудах хөдөлгөөнийг дуулах	Сурагч 2 хоолойгоор хөгжимддөг болно.
2.2г. Хөгжмийн энгийн зэмсгийн дуугаралтын ялгааг илэрхийлэн 2 хоолойгоор хөгжимдөх	Сурагч аялгууны чиглэл хөдөлгөөнийг хөдөлгөөнөөр илэрхийлдэг болно.
2.2д. Хөгжмийн зохиолын аялгууны чиглэл хөдөлгөөнийг мэдэрч, хөгжимт хөдөлгөөнөөр илэрхийлэх	

2.2.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч хөгжмийн дүрийг тодорхойлж чаддаг болно.	Янз бүрийн регистр дэх хөгжмийн дуу авиаг сонсоод өөр хооронд нь харьцуулж онцлог ялгаа /өнгө аяс/ шинж төрх, хүчийг тодорхойлдог.
2	Сурагч G1-C2 эгшгийг ноотоор дуулдаг болно.	G1-C2 хүрээнд хялбар дуу аялгууг ноотоор дуулдаг.
3	Сурагч 2 хоолойгоор хөгжимддөг болно.	Хөгжмийн энгийн зэмсэг ашиглан гоцлол, цөөхүүл хэлбэрээр 2 хоолойгоор хөгжимддөг.
4	Сурагч аялгууны чиглэл хөдөлгөөнийг хөдөлгөөнөөр илэрхийлдэг болно.	Хөгжмийн хэмнэлд тохируулж, хэрэгсэл ашиглан хөдөлгөөн хийдэг.

2.2.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Янз бүрийн регистр дэх хөгжмийн дуу авиаг сонсоод өөр хооронд нь харьцуулж онцлог ялгаа /өнгө аяс/ шинж төрх, хүчийг тодорхойлдог.	Байгалийн юмс үзэгдлийг хөгжмийн дуу авиа, өнгө аяс, хэмнэл, хурд хүчээр жишээлэн дүрсэлж харуулдаг.	Өгөгдсөн дүр төрх, шинж байдлыг зураглалаар илэрхийлдэг.	Сонссон дуу аялгууг дүрслэн зурах, бичих, гарын хөдөлгөөнөөр дүрсэлдэг.	Дуу авиаг өөрчлөлтийг харьцуулж тайлбарладаг.
G1-C2 хүрээнд хялбар дуу аялгууг ноотоор дуулдаг.	Өндрийн зураглалыг гарын дохиотой хослуулан дуулдаг.	Өрөг дараалсан хөдөлгөөн бүхий хялбар аялгууг ноотоор дуулдаг.	G1-C2 эгшгийн цувааг өгсөх, уруудах чиглэлээр янз бүрийн хэмнэлээр дуулдаг.	G1-C2 хүрээнд бүтэн, хагас, дөрөвт ноот ба тэдгээрийн зогсоцыг таньж дуулдаг.
Хөгжмийн энгийн зэмсэг ашиглан гоцлол, цөөхүүл хэлбэрээр 2 хоолойгоор хөгжимддөг.	Өгөгдсөн аялгуунд хөгжмийн хамсраа хийж хөгжимддөг.	Энгийн зэмсгийн дуугаралтын ялгааг илэрхийлэн гоцлолоор хөгжимддөг.	Хөгжмийн энгийн зэмсэг ашиглан цөөхүүл хэлбэрээр хөгжимддөг.	Хөгжмийн энгийн зэмсэг ашиглан хоёр хоолойн дасгал, дууг хөгжимддөг.
Хөгжмийн хэмнэлд тохируулж, хэрэгсэл ашиглан хөдөлгөөн хийдэг.	Аялгууны чиглэл, хэмнэлийг тодорхойлж чаддаг.	Аялгууны чиглэлд тохирох хөдөлгөөн хийдэг.	Хөгжмийн зохиолын утга агуулга, аялгууны шинж төрхийг янз бүрийн хэрэгсэл ашиглан хөдөлгөөнөөр илэрхийлдэг.	Аялгууны хүчтэй сул хувь, аялгууны өгсөх, уруудах, үсрэлттэй хөдөлгөөнийг хэрэгсэл ашиглан хөдөлгөөнөөр илэрхийлдэг.

2.3. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 3. ХӨГЖМИЙН ЭГШГИЙН ХӨДӨЛГӨӨН БА АЯЛГУУ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
2.3а. Хялбар дуу, аялгууг сонсоод, эгшгийн өндөр нам, урт богино, аялгууны чиглэл хөдөлгөөнийг зураглах	Сурагч хялбар дуу, аялгууг сонсоод зураглалаар илэрхийлдэг болно.
2.3б. F1-C1 эгшгийг дэвсгэр шугамд байрлуулж, ноотоор дуулахдаа үсгэн тэмдэглэгээ, зогсоцын тэмдгийг ашиглах	Сурагч F1-C1 эгшгийг ноотоор дуулдаг болно.
2.3в. Цэгтэй ноот, зогсоц бүхий хэмнэлээр 2 хоолойгоор хөгжимдөх	Сурагч цэгтэй ноот, зогсоц бүхий хэмнэлийг хөгжимддөг болно.
2.3г. Алчуур, тууз, савх, дарцаг зэрэг хэрэгсэл ашиглан хөгжимт хөдөлгөөн хийж гүйцэтгэх	Сурагч хэрэгсэл ашиглан хөгжимт хөдөлгөөн хийж гүйцэтгэдэг болно.
2.3д. Өгөгдсөн график зураглалаар /өгсөх, уруудах, давтах/ аялгуу зохиох	Сурагч өгсөх, уруудах, давтах хөдөлгөөнийг зураглалаар аялгуу зохиож чаддаг болно

2.3.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч хялбар дуу, аялгууг сонсоод зураглалаар илэрхийлдэг болно.	Хөгжмийн зохиолыг сонсоод, аялгууны шинж төрхийг тодорхойлж, зурагладаг. Хялбар дуу, аялгууны эгшгийн өндөр нам, урт богино, чиглэл хөдөлгөөнийг зурагладаг.
2	Сурагч F1-C1 эгшгийг ноотоор дуулдаг болно.	F1-C1 эгшгийг дэвсгэр шугамд байрлуулж, зогсоцын тэмдгийг таньж дуулдаг.
3	Сурагч цэгтэй ноот, зогсоц бүхий хэмнэлийг хөгжимддөг болно.	Хялбар дуу, дасгал дахь цэгтэй ноот, зогсоц бүхий хэмнэлийг хөгжимддөг.
4	Сурагч хэрэгсэл ашиглан хөгжимт хөдөлгөөн хийж гүйцэтгэдэг болно.	Алчуур, тууз, савх, дарцаг зэрэг хэрэгсэл ашиглан хөгжимт хөдөлгөөн гүйцэтгэдэг.
5	Сурагч өгсөх, уруудах, давтах хөдөлгөөний зураглалаар аялгуу зохиож чаддаг болно	Өгөгдсөн график зураглалын дагуу өгсөх, уруудах, давтах хөдөлгөөнтэй аялгуу зохиодог.

2.3.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Хөгжмийн зохиолыг сонсоод, аялгууны шинж төрхийг тодорхойлж, зурагладаг.	Хялбар дуу, аялгууны эгшгийн уртаашийг зурагладаг.	Хялбар дуу, аялгууны эгшгийн чиглэл хөдөлгөөнийг зурагладаг.	Хөгжим сонсоод дүр дүрслэлийг зураглаж үзүүлдэг.	Хөгжмийн зохиолыг сонсоод аялгууны шинж төрх, айзам хэмжээ, өнгө аяс, хэмнэл хурд, хүчний нийлэмжээр мэдэрч ойлгосноо тайлбарладаг.
F1-C1 эгшгийг дэвсгэр шугамд байрлуулж, зогсоцын тэмдгийг таньж дуулдаг.	F1-C1 эгшгийн цувааг дэвсгэр шугамд байрлуулж дуулдаг.	F1-C1 эгшгийг янз бүрийн дараалалд оруулж дуулдаг.	F1-C1 эгшгийг график дүрслэл, өгсөх, уруудах, давтах дарааллаар дуулдаг.	F1-C1 эгшгийн уртааш болон зогсоцын тэмдгийг таньж дуулдаг.
Хялбар дуу, дасгал дахь цэгтэй ноот, зогсоц бүхий хэмнэлийг хөгжимддөг.	Цэгтэй ноотыг хэмнэлээр хөгжимддөг.	Зогсоцыг өгөгдсөн хэмжээний дагуу хөгжимддөг.	Хялбар дуу, аялгууг хөгжимдөхдөө зогсоц /пауз/-г таньж тоглодог.	Хялбар дуу, дасгал дахь цэгтэй ноот, зогсоцыг таньж хөгжимддөг.
Алчуур, тууз, савх, дарцаг зэрэг хэрэгсэл ашиглан хөгжимт хөдөлгөөн хийж гүйцэтгэдэг.	Тойрон бүжиг, хөгжимт дасгал хийхдээ тууз, савх ашиглаж чаддаг.	Аялгууны хэмнэл, өнгө аяс, хурд хүчид тохируулан хэрэгсэл ашиглан хөгжимт хөдөлгөөн гүйцэтгэдэг.	Агуулга дүр дүрслэлийг хэрэгсэл ашиглан хөдөлгөөнөөр илэрхийлдэг.	Дуу, аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн зохиомжилж хэрэгсэл ашиглан илэрхийлдэг.
Өгөгдсөн график зураглалын дагуу өгсөх, уруудах, давтах хөдөлгөөнтэй аялгуу зохиодог.	Сонссон дуу аялгуугаа дүрслэн график дүрслэлээр илэрхийлдэг.	Хялбар дуу, аялгууны хэмнэлийг баяжуулан зурагладаг.	График зураглалын дагуу өгсөх, уруудах хөдөлгөөнөөр аялгуу зохиодог.	График зураглалын дагуу давтах хөдөлгөөнөөр аялгуу зохиодог.

2.4. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 4. АЯЛГУУНЫ ШИНЖ ТӨРХ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
2.4а. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг сонсож тодорхойлох, зураглах, амьтдын төрх араншинг илэрхийлэх	Сурагч хөгжмийн зохиолын шинж төрхийг сонсоод зурагладаг болно.
2.4б. С1-С2 цараанд хялбар дуу, дасгалыг ноотоор дуулахдаа дууны утга агуулгыг ойлгож, өнгө эгшиг, үг хэллэг, амьсгааг хянаж чадахаа харуулах	Сурагч С1-С2 цараанд хялбар дуу, дасгалыг ноотоор дуулдаг болно.
2.4в. Үгийн үеийг ашиглан хялбар хэмнэлийн цээж бичиг бичиж, хөгжимдөх	Сурагч хялбар хэмнэлийн цээж бичиг бичиж, хөгжимддөг болно.
2.4г. Тодорхой сэдвээр /эрвээхий, цэцэг, шувуухай/ хөгжимт хөдөлгөөн хийж, дүр төрхийг илэрхийлэх	Сурагч хөгжмийн зохиолын шинж төрхөд тохируулан тодорхой сэдвээр, хөдөлгөөн зохиомжилж чаддаг болно.
2.4д. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхөд тохируулан чөлөөт хөдөлгөөн зохиомжлох	

2.4.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч хөгжмийн зохиолын шинж төрхийг сонсоод зурагладаг болно.	Хөгжмийн зохиолыг сонсоод, аялгууны шинж төрхийг тодорхойлдог.
2	Сурагч С1-С2 цараанд хялбар дуу, дасгалыг ноотоор дуулдаг болно.	С1-С2 цараанд хялбар дуу, дасгалыг ноотоор дуулахдаа дууны утга агуулгыг ойлгож, өнгө эгшиг, үг хэллэг, амьсгааг хянаж чаддаг.
3	Сурагч хялбар хэмнэлийн цээж бичиг бичиж, хөгжимддөг болно.	Хэлц үг, оньсого, зүйр цэцэн үгийг ашиглан хэмнэлийн цээж бичиг бичиж, хөгжимддөг.
4	Сурагч хөгжмийн зохиолын шинж төрхөд тохируулан тодорхой сэдвээр, хөдөлгөөн зохиомжилж чаддаг болно	Эрвээхий, цэцэг, шувуухайн дүр төрхийг илэрхийлж хөгжимт хөдөлгөөн зохиомжилж гүйцэтгэдэг.

2.4.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Хөгжмийн зохиолыг сонсоод, аялгууны шинж төрхийг тодорхойлж зурагладаг.	Баавгай, хэрэм зохиолыг сонсоод аялгууг харьцуулж, дүрийг тодорхойлдог.	Байгалийн зураглалаас аялгууны шинж төрх, хүчийг мэдэрч илэрхийлдэг.	Хөгжмийн зохиолыг сонсоод утга агуулгыг хурд, хүчтэй холбон тайлбарладаг.	Хөгжмийн зохиолыг сонсоод утга агуулгыг шинж төрхтэй холбон тайлбарладаг.
С1-С2 цараанд хялбар дуу, дасгалыг ноотоор дуулахдаа дууны утга агуулгыг ойлгож, өнгө эгшиг, үг хэллэг, амьсгааг хянаж чаддаг.	Дууны утга агуулгыг ойлгож, хүчтэй сул хувийг илэрхийлж дуулдаг.	Дууны утга агуулгыг илэрхийлж уран яруу дуулдаг.	Дуулахдаа бусдыгаа сонсож өнгө эгшиг, үг хэллэг, амьсгааг хянаж чаддаг.	Хялбар дуу, дасгалыг ноотоор дуулахдаа утга агуулгыг сэтгэл хөдлөлттэй холбон илэрхийлдэг.

Хэлц үг, оньсого, зүйр цэцэн үгийг ашиглан хэмнэлийн цээж бичиг бичиж, хөгжимддөг.	Зүйр үгийг үеэр хувааж хэмнэлээр илэрхийлдэг.	Өгөгдсөн шүлгийг үеэр тасалж, хэмнэлжүүлэн алга ташилтаар илэрхийлдэг.	Өгөгдсөн хэмнэлийн цээж бичиг бичдэг.	Үүсгэсэн хэмнэлээ ноотонд шилжүүлэн хөгжимдөж үзүүлдэг.
Эрвээхий, цэцэг, шувуухайн дүр төрхийг илэрхийлж хөгжимт хөдөлгөөн гүйцэтгэдэг.	Сэтгэл хөдлөлөө илэрхийлж, ганцаараа болон анги хамт олноороо дүрд хувирч тоглодог.	Эрвээхий, шувуухай хөгжмийн айзам хэмжээ, хүчтэй сул хувийг хөдөлгөөнөөр /гүйх, үсрэх, харайх/ илэрхийлдэг.	Эрвээхий, цэцэг, шувуухайн шинж төрх, хэмнэлд тохируулан хөдөлгөөн зохиомжлон гүйцэтгэдэг.	Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхөд тохируулан чөлөөт хөдөлгөөн зохиомжилдог.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. III АНГИ

3. III АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

3.1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 1. ӨНГӨ АЯС, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
3.1а. Хөгжмийн зэмсгийн эгшиглэлтийн өнгө аясыг ялган таних, зэмсгүүдийг бүлэглэн тайлбарлах	Сурагч хөгжмийн уран бүтээлийг сонсоод, түүнийг тайлбарлаж чаддаг болно.
3.1б. Дууны ноот бичлэг дэх цэгтэй болон догол хэмнэлийг дуулах	Сурагч дууны ноот бичлэг дэх тэмдэглэгээг таньж дуулдаг болно.
3.1в. Бишгүүрээр G-H эгшгийн багтаамжид хөгжимдөх арга барил эзэмшсэнээ харуулах	Сурагч бишгүүр (пианика)-ээр дуу, дасгал, аялгууг хөгжимддөг болно.
3.1г. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, хэмнэлийн онцлогийг янз бүрийн хэрэгсэл ашиглан хөдөлгөөнөөр илэрхийлэх	Сурагч хөгжмийн зохиолын онцлогийг хөдөлгөөнөөр дүрслэдэг болно.
3.1д. Хөгжмийн зэмсгүүдийн дуу авиа үүсгэх арга замыг тодруулж ангилах	

3.1.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч хөгжмийн уран бүтээлийг сонсоод, түүнийг тайлбарлаж чаддаг болно.	Хөгжмийн зохиолыг сонсоод зэмсгийн эгшиглэлтийн өнгө аясыг ялган тайлбарладаг.
		Хөгжмийн уран бүтээлийн өнгө аяс, хурд, хүчний өөрчлөлтийг сонсож тодорхойлдог.
2	Сурагч дууны ноот бичлэг дэх тэмдэглэгээг таньж дуулдаг болно.	Дууны ноот бичлэг дэх цэгтэй болон догол хэмнэлийг дуулж чаддаг.
		Ноот бичлэг дэх хурд, хүчний тэмдэглэгээг таньж дуулдаг.
3	Сурагч бишгүүрээр дуу, дасгал, аялгууг хөгжимддөг болно.	G-H, G1-D2 эгшгийн цараанд дуу, дасгал, аялгууг ноотоор хөгжимдөхдөө хурд, хүчний тэмдэглэгээг илэрхийлж чаддаг.
4	Сурагч хөгжмийн зохиолын онцлогийг хөдөлгөөнөөр дүрслэдэг болно.	Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, хэмнэл, агуулга, дүр, өгүүлэмжийн онцлогийг янз бүрийн хэрэгсэл ашиглан хөдөлгөөнөөр илэрхийлдэг.
		Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг янз бүрийн хэлбэрээр зураглаж илэрхийлдэг.

3.1.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Хөгжмийн зохиолыг сонсоод зэмсгийн эгшиглэлтийн өнгө аясыг ялган тайлбарладаг.	Хөгжмийн зохиолыг сонсоод хөгжмийн зэмсгүүдийг нэрлэдэг.	Хөгжмийн зохиолыг сонсоод хөгжмийн зэмсгүүдийн өнгө аясыг тодорхойлдог.	Хөгжмийн зохиолыг сонсоод зэмсгүүдийг дуу авиа үүсгэх аргаар нь ангилдаг.	Хөгжмийн зохиолыг сонсоод зэмсгийн эгшиглэлтийн өнгө аясыг ялган бүлэглэж тайлбарладаг.
Хөгжмийн уран бүтээлийн өнгө аяс, хурд, хүчний өөрчлөлтийг сонсож тодорхойлдог.	Хөгжмийн бүтээлийг сонсоод аялгууны хурд, хүчийг тодорхойлдог.	Хөгжмийн бүтээлийг сонсоод аялгууны шинж төрхийг өөрийнхөөрөө тайлбарладаг.	Хөгжмийн уран бүтээлийг сонсоод хурд, хүчний өөрчлөлтийг тайлбарладаг.	Хөгжмийн уран бүтээлийн өнгө аяс, хурд, хүчний өөрчлөлтийг харьцуулан тайлбарладаг.
Дууны ноот бичлэг дэх цэгтэй болон догол хэмнэлийг дуулж чаддаг.	Дууны ноот бичлэгээс цэгтэй ноотыг олж чаддаг.	Дууны ноот бичлэгээс догол хэмнэлийг олж чаддаг.	Дууны ноот бичлэг дэх цэгтэй болон догол хэмнэлийг багшийн дэмжлэгтэй дуулдаг.	Дууны ноот бичлэг дэх цэгтэй болон догол хэмнэлийг дуулж чаддаг.
Ноот бичлэг дэх хурд, хүчний тэмдэглэгээг таньж дуулдаг.	Дууны ноот бичлэг дэх тэмдэг тэмдэглэгээг таньж нэрлэдэг.	Дууг дуулахдаа хурд, хүчийг илэрхийлэн дуулдаг.	Дууг дуулахдаа ноот бичлэг дэх хурдны тэмдэглэгээг илэрхийлэн дуулдаг.	Дууг дуулахдаа ноот бичлэг дэх хурд, хүчний тэмдэглэгээний дагуу дуулдаг.
G-H, G1-D2 эгшгийн цараанд дуу, дасгал, аялгууг ноотоор хөгжимдөхдөө хурд, хүчний тэмдэглэгээг илэрхийлж чаддаг.	G-H эгшгийн цараанд дуу, дасгал, аялгууг ноотоор хөгжимддөг.	G1-D2 эгшгийн цараанд дуу, дасгал, аялгууг ноотоор хөгжимддөг.	G-H, G1-D2 эгшгийн цараанд дуу, дасгал, аялгууны хурдны тэмдгийг илэрхийлж хөгжимддөг.	G-H, G1-D2 эгшгийн цараанд дуу, дасгал, аялгууг ноотоор хөгжимдөхдөө хурд, хүчний тэмдэглэгээг илэрхийлж чаддаг.
Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, хэмнэл, агуулга, дүр, өгүүлэмжийн онцлогийг янз бүрийн хэрэгсэл ашиглан хөдөлгөөнөөр илэрхийлдэг.	Хөгжмийн зохиолын аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийдэг.	Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, хэмнэлийг янз бүрийн хэрэгсэл ашиглан хөдөлгөөнөөр илэрхийлдэг.	Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, хэмнэл, агуулга, дүр, өгүүлэмжийн онцлогийг хөдөлгөөнөөр илэрхийлдэг.	Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрх, хэмнэл, агуулга, дүр, өгүүлэмжийн онцлогийг янз бүрийн хэрэгсэл ашиглан хөдөлгөөнөөр илэрхийлдэг.
Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг янз бүрийн хэлбэрээр зураглаж илэрхийлдэг.	Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг тайлбарладаг.	Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг зураглаж илэрхийлдэг.	Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг янз бүрийн аргаар илэрхийлдэг.	Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг янз бүрийн хэлбэрээр зураглаж илэрхийлдэг.

3.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 2. ХУРД, ХҮЧДЭЛ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
3.2а. Хөгжмийн уран бүтээлээс өнгө аяс, хурд, хүчний өөрчлөлтийг сонсож тодорхойлох	Сурагч хөгжмийн уран бүтээлээс /хурд, хүчийг/ уран илэрхийллийн аргыг ялгаж тодорхойлдог болно.
3.2б. Ноот бичлэгээс хурд, хүчний тэмдэглэгээг таньж, гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулах	Сурагч гоцлол цөөхүүл хэлбэрээр дуулдаг болно.
3.2в. G1-D2 цараанд дуу, дасгал, аялгууг ноотоор хөгжимдөхдөө хурд, хүчний тэмдэглэгээг илэрхийлэх	Сурагч ноотоор хөгжимдөхдөө тэмдэг тэмдэглэгээг илэрхийлж чаддаг болно.
3.2г. Хөгжмийн зохиолын агуулга, дүр, өгүүлэмжийн онцлог шинжийг хөдөлгөөнөөр дүрслэх	Сурагч хөгжмийн уран бүтээлийг сонсоод, хурд, хүчний өөрчлөлтийг хөдөлгөөнөөр илэрхийлдэг болно.
3.2д. Хөгжмийн зохиолын аялгууны шинж төрхийг зураглалаар илэрхийлэх	

3.2.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч хөгжмийн уран бүтээлээс /хурд, хүчийг/ уран илэрхийллийн аргыг ялгаж тодорхойлдог болно.	Хөгжмийн уран бүтээлийг сонсоод, хурд, хүчний өөрчлөлтийг тодорхойлдог.
2	Сурагч гоцлол цөөхүүл хэлбэрээр дуулдаг болно.	Гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулахдаа бусдын дуулалтыг сонсож, хөг, хэмнэл нийлүүлдэг.
3	Сурагч ноотоор хөгжимдөхдөө тэмдэг тэмдэглэгээг илэрхийлж чаддаг болно.	Гоцлол, хоршил, гурвал, дөрвөл хэлбэрээр хөгжимдөхдөө хурд хүчний тэмдэглэгээг илэрхийлдэг.
4	Сурагч хөгжмийн уран бүтээлийг сонсоод, хурд, хүчний өөрчлөлтийг хөдөлгөөнөөр илэрхийлдэг болно.	Аялгууны шинж төрх, хөгжмийн зэмсгийн эгшиглэлт, хурд, эгшиглэх хүч зэргийг хөдөлгөөнөөр илэрхийлдэг.

3.2.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Хөгжмийн уран бүтээлийг сонсоод, хурд, хүчний өөрчлөлтийг тодорхойлдог.	Хөгжмийн уран бүтээлийг сонсоод аялгууны хурд, хүчийг ялгадаг	Хөгжмийн уран бүтээлийг сонсоод аялгууны хурд, хүчний өөрчлөлтийг тэмдэглэдэг.	Хөгжмийн уран бүтээлийг сонсоод, хурд, хүч хэрхэн өөрчлөгдөж байгааг тайлбарладаг.	Хөгжмийн уран бүтээлийг сонсоод, хурд, хүчний өөрчлөлтийг утга агуулгатай холбон тайлбарладаг
Гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулахдаа бусдын дуулалтыг сонсож, хөг, хэмнэл нийлүүлдэг.	Дууг цөөхүүл хэлбэрээр дуулахдаа бусдыг сонсож дагадаг.	Гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулахдаа тэмдэг тэмдэглэгээг илэрхийлж чаддаг.	Гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулахдаа хөг, хэмнэл нийцүүлдэг.	Гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулахдаа бусдын дуулалтыг сонсож, хөг, хэмнэл нийлүүлдэг.

Гоцлол, хоршил, гурвал, дөрвөл хэлбэрээр хөгжимдөхдөө хурд хүчний тэмдэглэгээг илэрхийлдэг.	Гоцлол хэлбэрээр хөгжимдөхдөө хурд хүчний тэмдэглэгээг илэрхийлдэг.	Гоцлол, хоршил хэлбэрээр хөгжимдөхдөө бусдыгаа сонсож хөг, хэмнэл нийцүүлдэг.	Гурвал, дөрвөл хэлбэрээр хөгжимдөхдөө тэмдэг тэмдэглэгээг илэрхийлдэг.	Гоцлол, хоршил, гурвал, дөрвөл хэлбэрээр ноотоор хөгжимдөхдөө хурд хүчний тэмдэглэгээг илэрхийлдэг.
Аялгууны шинж төрх, хөгжмийн зэмсгийн эгшиглэлт, хурд, эгшиглэх хүч зэргийг хөдөлгөөнөөр илэрхийлдэг.	Хөгжимт хөдөлгөөн гүйцэтгэхдээ аялгууны хурдыг мэдэрч хөдөлгөөнөө удирддаг.	Хөгжимт хөдөлгөөн гүйцэтгэхдээ аялгууны хурд, хүчийг мэдэрч хөдөлгөөнөө удирддаг.	Хөгжимт хөдөлгөөн гүйцэтгэхдээ аялгууны шинж төрхийг мэдэрч хөдөлгөөнөө удирддаг.	Хөгжимт хөдөлгөөн гүйцэтгэхдээ аялгууны хурд, хүч, шинж төрх, зэмсгийн эгшиглэлтийг мэдэрч хөдөлгөөнөө удирддаг.

3.3. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 3. ХӨГЖМИЙН БАЙГУУЛАМЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
3.3а. Хөгжмийн уран бүтээлийг сонсоод, бүрэлдэхүүнийг (гоцлол, цөөхүүл, найрал) тодорхойлох, тайлбарлах	Сурагч хөгжмийн уран бүтээлийг сонсоод, бүрэлдэхүүнийг тайлбарладаг болно.
3.3б. Дууны уран бүтээл дэх давталт ялгарамжийг (бадаг, дахилт, тухайлбар, өгүүлбэр) тодорхойлж, гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулах	Сурагч дууны уран бүтээл дэх давталт ялгарамжийг тодорхойлж, дуулдаг болно.
3.3в. C1-D2 цараанд ноотоор хөгжимдөх, дуу, аялгуун дахь давталт ялгарамжийг (тухайлбар, өгүүлбэр) тодорхойлох	Сурагч C1-D2 цараанд ноотоор хөгжимддөг болно.
3.4в. C1-D2 цараанд удирдаачийн дохиогоор хөгжимдөх	Сурагч хөгжмийн зохиолын бүтцийг илэрхийлж чаддаг болно.
3.3г. Хөгжмийн зохиолын аялгууны бүтэц хэсгийг мэдэрснээ хөдөлгөөний шилжилт, өөрчлөлтөөр илэрхийлэх	Сурагч өгөгдсөн хэмнэлийг хувилбарлан хөгжүүлдэг болно.
3.3д. Өгсөн хэмнэлийг хувилбарлан хөгжүүлэх /A1,A2,A3/	

3.3.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч хөгжмийн уран бүтээлийг сонсоод, бүрэлдэхүүнийг тайлбарладаг болно.	Хөгжмийн уран бүтээлийг сонсоод, гоцлол, цөөхүүл, найрал бүрэлдэхүүнийг тайлбарладаг.
2	Сурагч дууны уран бүтээл дэх давталт ялгарамжийг тодорхойлж, дуулдаг болно.	Дууны уран бүтээл дэх бадаг, дахилт, тухайлбар, өгүүлбэрийг тодорхойлж, гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулдаг.
3	Сурагч C1-D2 цараанд ноотоор хөгжимддөг болно.	C1-D2 цараанд дуу, аялгуун дахь давталт ялгарамжийг (тухайлбар, өгүүлбэр) тодорхойлж, удирдаачийн дохиогоор ноотоор хөгжимддөг.
4	Сурагч хөгжмийн зохиолын бүтцийг илэрхийлж чаддаг болно.	Хөгжмийн зохиолын аялгууны бүтцийг мэдэрснээ хөдөлгөөний шилжилт, өөрчлөлтөөр илэрхийлдэг.
5	Сурагч өгөгдсөн хэмнэлийг хувилбарлан хөгжүүлдэг болно.	Өгөгдсөн хэмнэлийг хувилбарлан хөгжүүлж зохиомжилдог. /A1, A2, A3/

3.3.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Хөгжмийн уран бүтээлийг сонсоод, гоцлол, цөөхүүл, найрал бүрэлдэхүүнийг тайлбарладаг.	Хөгжмийн уран бүтээлийг сонсоод бүрэлдэхүүнийг тодорхойлдог.	Гоцлол, найрал бүрэлдэхүүнд бичигдсэн хөгжмийн уран бүтээлийг сонсоод зурагладаг.	Хөгжмийн уран бүтээлийг сонсоод, гоцлол, цөөхүүл, найрал бүрэлдэхүүний ялгааг харьцуулдаг.	Хөгжмийн уран бүтээлийг сонсоод, гоцлол, цөөхүүл, найрал бүрэлдэхүүний онцлог ялгааг тайлбарладаг.
Дууны уран бүтээл дэх бадаг, дахилт, тухайлбар, өгүүлбэрийг тодорхойлж, гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулдаг.	Дууны бадаг, дахилт хэсгийг нэрлэж, цөөхүүл хэлбэрээр дуулдаг.	Дууны уран бүтээл дэх бадаг, дахилт, өгүүлбэрийг тодорхойлж, цөөхүүл хэлбэрээр дуулдаг.	Дууны уран бүтээл дэх бадаг, дахилт, тухайлбар, өгүүлбэрийг тодорхойлж, гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулдаг.	Дууны уран бүтээл дэх бадаг, дахилт, тухайлбар, өгүүлбэрийг тодорхойлж, гоцлол, цөөхүүл хэлбэрээр дуулдаг.
C1-D2 цараанд дуу, аялгуун дахь давталт ялгарамжийг (тухайлбар, өгүүлбэр) тодорхойлж, удирдаачийн дохиогоор ноотоор хөгжимддөг.	C1-D2 цараанд дуу, аялгууг даган хөгжимддөг.	C1-D2 цараанд дуу, аялгуун дахь давталт ялгарамжийг (тухайлбар, өгүүлбэр) тодорхойлж хөгжимддөг.	C1-D2 цараанд дуу, аялгуун дахь давталт ялгарамжийг (тухайлбар, өгүүлбэр) тодорхойлж, удирдаачийн дохиогоор хөгжимддөг.	C1-D2 цараанд дуу, аялгуун дахь давталт ялгарамжийг (тухайлбар, өгүүлбэр) тодорхойлж, удирдаачийн дохиогоор ноотоор хөгжимддөг.
Хөгжмийн зохиолын аялгууны бүтцийг мэдэрснээ хөдөлгөөний шилжилт, өөрчлөлтөөр илэрхийлдэг.	Хөгжмийн зохиолын аялгууг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулдаг.	Хөгжмийн зохиолын аялгууны бүтэц өөрчлөгдөхийг мэдэрч хөдөлгөөнөө зохицуулдаг.	Хөгжмийн зохиолын аялгууны бүтцийг мэдэрснээ хөдөлгөөний шилжилт, өөрчлөлтөөр илэрхийлдэг.	Хөгжмийн зохиолын аялгууны бүтцийг мэдэрч хөдөлгөөн нэмж зохиомжилдог
Өгсөн хэмнэлийг хувилбарлан хөгжүүлж зохиомжилдог. /A1, A2, A3/	Өгсөн хэмнэлийг хувилбарлан хөгжүүлдэг. /A1, A2/	Өгсөн хэмнэлийг хувилбарлан хөгжүүлж, дөрөвт ноотоор энгийн хэмнэл зохиомжилдог. /A1, A2/	Өгсөн хэмнэлийг хувилбарлан хөгжүүлж, дөрөвт, наймт ноотуудаар энгийн хэмнэл зохиомжилдог. /A1, A2, A3/	Өгсөн хэмнэлийг хувилбарлан хөгжүүлж, хагас, бүтэн ноотуудаар энгийн дасгал зохиомжилдог. /A1, A2, A3/

3.4. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 4. ХӨГЖМИЙН ЦАРАА, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
3.4а. Хөгжмийн уран бүтээлийн аялгууны шинж төрх, хурд хүчний өөрчлөлтөөр зохиолын өгүүлэмжийг тайлбарлах	Сурагч хөгжмийн уран бүтээлийн өгүүлэмжийг тайлбарладаг болно.
3.4б. Дууны шүлгийн утга санаа, аялгууны шинж төрхийг тайлбарлах, удирдаачийн дохиогоор дуулах	Сурагч удирдаачийн дохиогоор дуулдаг болно.
3.4г. Хөгжимт дасгалыг янз бүрийн хэрэгсэлтэй гүйцэтгэх	Сурагч хөгжимт дасгалыг гүйцэтгэдэг болно.
3.4д. Өгөгдсөн хэмд хэмнэлийн янз бүрийн багцлал зохиох	Сурагч өгөгдсөн хэмд хэмнэлийн багцлал зохиодог болно.

3.4.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч хөгжмийн уран бүтээлийн өгүүлэмжийг тайлбарладаг болно.	Хөгжмийн уран бүтээлийн аялгууны шинж төрх, хурд хүчний өөрчлөлтөөр зохиолын өгүүлэмжийг тайлбарладаг.
2	Сурагч удирдаачийн дохиогоор дуулдаг болно.	Удирдаачийн дохиогоор дуулахдаа дууны шүлгийн утга санаа, аялгууны шинж төрхийг илэрхийлдэг.
3	Сурагч хөгжимт дасгалыг гүйцэтгэдэг болно.	Хөгжимт дасгалыг янз бүрийн хэрэгсэл (алчуур, тууз, бөмбөг...)-тэй гүйцэтгэдэг.
4	Сурагч өгөгдсөн хэмд хэмнэлийн багцлал зохиодог болно.	Өгөгдсөн хэм (2/4, 3/4, 4/4)-д хэмнэлийн янз бүрийн багцлал зохиодог.

3.4.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Хөгжмийн уран бүтээлийн аялгууны шинж төрх, хурд хүчний өөрчлөлтөөр зохиолын өгүүлэмжийг тайлбарладаг.	Хөгжмийн уран бүтээлийг сонсоод аялгууны шинж төрхийг тодорхойлдог.	Хөгжмийн уран бүтээлийг сонсоод хурд хүч, утга агуулгыг тайлбарладаг.	Хөгжмийн уран бүтээлийн аялгууны шинж төрх, хурд хүчний өөрчлөлтөөр зохиолын өгүүлэмжийг тайлбарладаг.	Хөгжмийн уран бүтээлийн аялгууны шинж төрх, хурд хүчний өөрчлөлтөөр зохиолын өгүүлэмжийг уран сэтгэмжтэй тайлбарладаг.
Удирдаачийн дохиогоор дуулахдаа дууны шүлгийн утга санаа, аялгууны шинж төрхийг илэрхийлдэг.	Дууг удирдаачийн дохиогоор дуулдаг.	Дууг удирдаачийн дохиогоор дуулахдаа дууны аялгууны шинж төрхийг илэрхийлдэг.	Удирдаачийн дохиогоор дуулахдаа дууны шүлгийн утга санаа, аялгууны шинж төрхийг илэрхийлдэг.	Удирдаачийн дохиогоор дуулахдаа дууны шүлгийн утга санаа, аялгууны шинж төрхийг хурд, хүчний өөрчлөлтөөр илэрхийлж дуулдаг

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Хөгжимт дасгалыг янз бүрийн хэрэгсэл (алчуур, тууз, бөмбөг...)-тэй гүйцэтгэдэг.	Хөгжимт дасгалыг хэрэгсэлгүй гүйцэтгэдэг.	Хөгжимт дасгалыг янз бүрийн хэрэгсэл (алчуур, тууз, бөмбөг...)-тэй гүйцэтгэдэг.	Хөгжимт дасгалыг аялгууны хэмнэлд тохируулан янз бүрийн хэрэгсэл (алчуур, тууз, бөмбөг...)-тэй гүйцэтгэдэг.	Хөгжимт дасгалыг янз бүрийн хэрэгсэл (алчуур, тууз, бөмбөг...)-тэй аялгууны хэмнэл, шинж төрхийг мэдэрч гүйцэтгэдэг.
Өгөгдсөн хэм (2/4, 3/4, 4/4)-д хэмнэлийн янз бүрийн багцлал зохиодог.	2/4 хэмд хэмнэлийн багцлал зохиодог.	Өгөгдсөн хэм (2/4, 3/4,)-д дөрөвт, наймт, хагас ноот оролцуулан хэмнэлийн багцлал зохиодог.	Өгөгдсөн хэм (2/4, 3/4, 4/4)-д хэмнэлийн янз бүрийн багцлал зохиодог.	Өгөгдсөн хэм (2/4, 3/4, 4/4)-д цэгтэй болон догол хэмнэл оролцуулан янз бүрийн хэмнэлийн багцлал зохиодог.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. IV АНГИ

4. IV АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

4.1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 1. СЭТГЭЛ ХӨДЛӨЛ БА ХӨГЖИМ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
4.1а. Хөгжмийн зохиолын лад хөгийг /мажор, минор/ ялган сонсох, агуулга дүрийг тайлбарлах	Сурагч хөгжмөөс эгшиглэгээний өнгө аясыг мэдэрч чаддаг болно.
4.1б. Мажор, минорын ладад хялбар аялгууг ноотоор дуулах	Сурагч хялбар дуу дасгалыг дуулж чаддаг болно.
Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
7.1а. Монгол ардын дуу хөгжмийн төрөл зүйл, илэрхийллийн арга барил, онцлог, ялгааг тодорхойлох, тайлбарлах	Сурагч монгол ардын дуу хөгжмөөс сонсоод төрлүүдийг ялгаж тодорхойлдог болно.
7.1б. Өгүүлэх эрхтний шүтэлцээт урлаг хөөмийн төрлүүдийг (исгэрээ, шахаа, хархираа) сонсож таних, тодорхойлох	Сурагч язгуур урлагийн төрлүүдийг сонсоод ялган тодорхойлдог болно.
7.1в. Хөгжимт аман зохиолын төрлүүдийг сонсож таних, сурснаа жишээгээр харуулах, монголчуудын ахуй, аж байдалтай холбон тайлбарлах	Сурагч язгуур урлагийн төрлүүдийн аль нэгээс сонгон суралцсанаа жишээгээр харуулдаг болно.

2.1.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч монгол ардын дуу хөгжмөөс сонсоод төрлүүдийг ялгаж тодорхойлдог болно.	Монгол ардын дуу хөгжмөөс сонсоод төрөл зүйлийг онцлог, илэрхийллийн арга барилаар нь ялгаж тайлбарладаг.
2	Сурагч язгуур урлагийн төрлүүдийг сонсоод ялган таньдаг болно.	Хөөмийн төрлүүдийг/ исгэрээ, шахаа, хархираа/ сонсож ялгадаг. Хөгжимт аман зохиолын төрлүүдийг сонсоод ялгаж бүлэглэдэг.
3	Сурагч язгуур урлагийн төрлүүдээс суралцсанаа жишээгээр харуулдаг болно.	Язгуур урлагийн төрлөөс сонгон суралцсанаа дуулж, хөгжимдөж, бүжиглэж харуулдаг.

2.1.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Монгол ардын дуу хөгжмөөс сонсоод төрөл зүйлийг онцлог, илэрхийллийн арга барилаар нь ялгаж тайлбарладаг.	Монгол ардын урлагийн төрлүүдийг нэрлэдэг.	Монгол ардын урлагийн төрлүүдийн онцлогийг ялган тайлбарладаг.	Монгол ардын дуу хөгжмөөс сонсоод илэрхийлэх арга барилыг уран бүтээлийн жишээгээр тайлбарладаг.	Монгол ардын дуу хөгжмөөс сонсоод төрөл зүйлүүдийг илэрхийллийн арга, онцлогоор нь харьцуулан ялгааг зураглаж үзүүлдэг.
Хөөмийн төрлүүдийг/ исгэрээ, шахаа, хархираа/ сонсож ялгадаг.	Хөөмийн төрлүүдийг сонсож ялган таньдаг, нэрлэдэг.	Хөөмийн төрлүүдийг сонсоод онцлог шинжээр нь харьцуулж, ялгааг тайлбарладаг.	Хөгжмийн уран бүтээлд хөөмийн төрлүүдийг ашигласан найруулгын талаар тайлбарладаг.	Хөөмийн төрлүүдээс сонгон хялбар дуу аялгууг хөөмийлэх оролдлого хийдэг.

Хөгжимт аман зохиолын төрлүүдийг сонсоод ялгаж бүлэглэдэг.	Хөгжимт аман зохиолын төрлүүдийг сонсоод ялгаж нэрлэдэг.	Хөгжимт аман зохиолын төрлүүдийн илэрхийллийн арга барилыг харьцуулдаг.	Хөгжимт аман зохиолын төрлүүдийг сонсоод ялгааг харьцуулан дүгнэлт гаргадаг.	Хөгжимт аман зохиолын төрлүүдээс гүйцэтгэж үзүүлдэг.
Язгуур урлагийн аль нэг төрлөөс сонгон суралцдаг.	Язгуур урлагийн энгийн хялбар төрлөөс сонгон суралцахыг хичээдэг.	Язгуур урлагийн өөрийн сонирхсон язгуур урлагийн төрлөөс сонгон суралцсанаа харуулдаг.	Язгуур урлагийн аль нэг төрлөөс сонгон суралцсанаа жишээгээр харуулдаг.	Язгуур урлагийн төрлүүдээс сонгон суралцсанаа гүйцэтгэж харуулдаг.

2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 2. МОНГОЛ АРДЫН ДУУ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
7.1г. Монгол ардын дууны төрөл, дуулах хэв маяг, арга барил, онцлогийг бусад үндэстний дуутай харьцуулах, дуулж үзүүлэх	Сурагч монгол ардын дууны онцлогийг бусад үндэстний дуунаас ялган таньдаг болно.
7.1д. Монгол ардын дууны уран бүтээлээс дуулахдаа хоолойн цараа, амьсгааны техник, айзмын өөрчлөлт, аялгууны үсрэлтийг мэдэрч, дуулах	Сурагч монгол ардын дуунаас дуулдаг болно.

2.2.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч монгол ардын дууны онцлогийг бусад үндэстний дуунаас ялган таньдаг болно.	Монгол ардын болон бусад үндэстний дууны төрөл, дуулах хэв маяг, онцлогийг тайлбарладаг.
2	Сурагч монгол ардын дуунаас дуулж чаддаг болно.	Монгол ардын дууг дуулахдаа ардын дууны уламжлалт донж маягийг илэрхийлэн дуулдаг.

2.2.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Монгол ардын болон бусад үндэстний дууны төрөл, дуулах хэв маяг, онцлогийг тайлбарладаг.	Монгол ардын болон бусад үндэстний дуунаас нэрлэж, төрлийг тодорхойлдог.	Монгол ардын болон бусад үндэстний дууны уран бүтээлээс сонсоод хэв маяг, онцлогийг жишээгээр тайлбарладаг.	Монгол ардын болон бусад үндэстний дууны хэв маяг, арга барил онцлогийг харьцуулан дүгнэлт гаргадаг.	Монгол ардын болон бусад үндэстний дууны уламжлалт донж маягийг тайлбарладаг.
Монгол ардын дууг дуулахдаа ардын дууны уламжлалт донж маягийг илэрхийлэн дуулдаг.	Монгол ардын дууны донж маяг, онцлогийг тайлбарладаг.	Монгол ардын дууг бусад үндэстний дуутай харьцуулан тайлбарладаг.	Монгол ардын дууны уламжлалт донж маяг, айзам хэмжээг мэдэрч дуулдаг.	Монгол ардын дууны уламжлалт донж маягийг орчин үеийн хэв маягт оруулж баяжуулан дуулдаг.

2.3. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 3. МОНГОЛ АРДЫН ХӨГЖИМ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
7.1е. Монгол үндэсний хөгжмийн зэмсгүүдийн төрөл, эгшиглэгээ, хөгжимдөх арга барил, онцлогийг тайлбарлах, сонсож таних 7.1ж. Үндэсний хөгжимд зориулсан бүтээлийг сонсоод агуулга дүр, хэлбэр бүтэц, зэмсэгжилтийг тодорхойлох, сэдэв аялгууг ноотоор аялах	Сурагч үндэсний хөгжимд зориулсан бүтээлийг сонсоод зэмсгүүдийн эгшиглэлтийн онцлог, хөгжимдөх арга барилыг тайлбарлаж чаддаг болно.
7.2в. Монгол ардын дууны уран бүтээлээс сонголт хийж, бишгүүрээр болон өөрийн сонгосон хөгжмийн зэмсгээр тэмдэг, тэмдэглэгээг зөв илэрхийлж ноотоор хөгжимдөх	Сурагч үндэсний хөгжимд зориулсан бүтээлээс сонсоод зэмсэгжилт, бүтцийг тодорхойлдог болно. Монгол ардын дуунаас сонгон хөгжимдөж чаддаг болно.

2.3.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч үндэсний хөгжимд зориулсан бүтээлийг сонсоод зэмсгүүдийн эгшиглэлтийн онцлог, хөгжимдөх арга барилыг тайлбарлаж чаддаг болно.	Үндэсний хөгжимд зориулсан бүтээлийг сонсоод хөгжмийн зэмсэгжилт, эгшиглэлтийн онцлогийг ялгаж чаддаг Үндэсний хөгжимд зориулсан бүтээлийг сонсоод хөгжмийн зэмсгүүдийн хөгжимдөх арга барилыг тайлбарладаг.
2	Сурагч үндэсний хөгжимд зориулсан бүтээлээс сонсоод зэмсэгжилт, бүтцийг тодорхойлдог болно.	Үндэсний хөгжимд зориулсан бүтээлийг сонсоод агуулга дүр, хэлбэр бүтцийг тодорхойлдог.
	Монгол ардын дуунаас сонгон хөгжимдөж чаддаг болно.	Монгол ардын дуунаас сонгон өөрийн сонгосон хөгжмийн зэмсгээр тэмдэг, тэмдэглэгээний дагуу ноотоор хөгжимддөг.

2.3.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Үндэсний хөгжимд зориулсан бүтээлийг сонсоод хөгжмийн зэмсэгжилт, эгшиглэлтийн онцлогийг ялгаж чаддаг.	Үндэсний хөгжмийн зэмсгүүдийг нэрлэж бүлэглэдэг.	Үндэсний хөгжимд зориулсан бүтээлийг сонсоод зэмсэгжилтийг тодорхойлж ангилдаг.	Үндэсний хөгжмийн зэмсгүүдийн эгшиглэгээний онцлогийг харьцуулан зурагладаг.	Үндэсний хөгжмийн зэмсгүүдийн тухай домог түүхийн материал цуглуулж дүгнэлт гаргадаг.
Үндэсний хөгжимд зориулсан бүтээлийг сонсоод хөгжмийн зэмсгүүдийн хөгжимдөх арга барилыг тайлбарладаг.	Үндэсний хөгжимд зориулсан бүтээлийг сонсоод зэмсгүүдийг таньж нэрлэдэг	Үндэсний хөгжимд зориулсан бүтээлийг сонсоод зэмсгүүдийн үүргийг тайлбарладаг.	Үндэсний хөгжимд зориулсан бүтээлийг сонсоод зэмсгүүдийн хөгжимдөх арга барилыг жишиж тайлбарладаг.	Дан хөгжмийн бүтээлийн утга агуулгыг хөгжмийн зэмсгийн эгшиглэгээний онцлогтой холбон тайлбарладаг.

Үндэсний хөгжимд зориулсан бүтээлийг сонсоод агуулга дүр, хэлбэр бүтцийг тодорхойлдог.	Үндэсний хөгжимд зориулсан бүтээлийг сонсоод дүрийг тодорхойлдог.	Үндэсний хөгжимд зориулсан бүтээлээс үзэж сонсоод агуулгыг тайлбарлаж зурагладаг.	Үндэсний хөгжимд зориулсан бүтээлээс үзэж сонсоод хэлбэрийг тодорхойлдог.	Үндэсний хөгжимд зориулсан бүтээлээс үзэж сонсоод бүтцийг агуулга, дүртэй холбон тайлбарладаг.
Монгол ардын дуунаас сонгон өөрийн сонгосон хөгжмийн зэмсгээр тэмдэг, тэмдэглэгээний дагуу ноотоор хөгжимддөг.	Монгол ардын дууны ноот бичвэр дэх тэмдэг тэмдэглэгээг таньж нэрлэдэг.	Монгол ардын дууг хөгжимдөх арга барилыг тайлбарлан, хөгжимддөг.	Монгол ардын дууны донж хэв маягийг илэрхийлэн хурд, хүчийг тохируулан хөгжимддөг.	Монгол ардын дууг өөрийн сонгосон хөгжмийн зэмсгээр тэмдэг, тэмдэглэгээний дагуу ноотоор хөгжимддөг.

2.4. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 4. МОНГОЛ АРДЫН БҮЖИГ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
7.13. Монгол ардын бүжиглэх урлаг, язгуур бий биелгээний төрөл, онцлогийг монголчуудын амьдрал ахуйтай холбон жишээгээр тайлбарлах	Сурагч монгол ардын бүжгийн урлагийн онцлогийг тайлбарладаг болно.
7.1и. Язгуур бий биелгээний дөрвөн зохицолт хөдөлгөөн (гар хөлийн байрлал, үндсэн суудал, мөр цээжний хөдөлгөөн)- ийг эзэмшсэнээ харуулах	Язгуур бий биелгээний үндсэн хөдөлгөөнөөс гүйцэтгэж чаддаг болно.

2.4.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч монгол ардын бүжгийн урлагийн онцлогийг тайлбарладаг болно.	Монгол ардын бүжиглэх урлаг, язгуур бий биелгээний онцлогийг уламжлалт аж байдалтай холбон жишээгээр тайлбарладаг.
2	Язгуур бий биелгээний үндсэн хөдөлгөөнөөс гүйцэтгэж чаддаг болно.	Язгуур бий биелгээний дөрвөн зохицолт хөдөлгөөн (гар хөлийн байрлал, үндсэн суудал, мөр цээжний хөдөлгөөн)- ийг эзэмшсэнээ гүйцэтгэж харуулдаг.

2.4.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Монгол ардын бүжиглэх урлаг, язгуур бий биелгээний онцлогийг уламжлалт аж байдалтай холбон жишээгээр тайлбарладаг.	Монгол ардын бүжиглэх урлаг, язгуур бий биелгээний хөдөлгөөнийг харьцуулан тайлбарладаг.	Монгол ардын бүжгийн онцлогийг хөдөлгөөнөөр үзүүлж тайлбарладаг.	Язгуур бий биелгээний онцлогийг хөдөлгөөнөөр үзүүлж тайлбарладаг.	Язгуур биелгээний төрлүүд болон зохиомжит бүжгийг харьцуулж, ялгааг тайлбарлан дүгнэлт гаргадаг.
Язгуур бий биелгээний дөрвөн зохицолт хөдөлгөөн (гар хөлийн байрлал, үндсэн суудал, мөр цээжний хөдөлгөөн)- ийг эзэмшсэнээ харуулдаг.	Язгуур бий биелгээний дөрвөн зохицолт хөдөлгөөнийг нэрлээд зарим хөдөлгөөнийг гүйцэтгэж үзүүлдэг.	Язгуур бий биелгээний хөдөлгөөнийг зураг болон дүрс бичлэгээс үзээд дуурайн гүйцэтгэдэг	Язгуур бий биелгээг ахуй амьдралтай холбон тайлбарлаж гүйцэтгэдэг.	Язгуур бий биелгээний хөдөлгөөнийг зохиомжлон гүйцэтгэдэг.

2.5. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 5. МОНГОЛ АРДЫН ДУУ ХӨГЖМИЙН УЛАМЖЛАЛ ШИНЭЧЛЭЛ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
7.2а. Орчин цагийн мэргэжлийн хөгжмийн бүтээл дэх уламжлалт төрлүүдийг сонсож тодорхойлох	Сурагч орчин цагийн хөгжмийн уран бүтээлээс сонсоод, уран бүтээлдээ авч ашигласан уламжлалт төрлүүдийг ялгаж чаддаг болно.
7.2б. Этник хамтлагуудын уран бүтээлээс сонгон хөгжимдөх арга маяг, зэмсгүүдийн өнгө дуурьсал, уран бүтээлдээ авч ашигласан ардын дуу хөгжмийг тодорхойлох, тайлбарлах	Сурагч монгол ардын урлагийн төрлүүдээс сонгон орчин үеийн хөгжмийн урлагтай хослуулан зохиомж хийж чаддаг болно.

2.5.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч орчин цагийн хөгжмийн уран бүтээлээс сонсоод, уран бүтээлдээ авч ашигласан уламжлалт төрлүүдийг ялгаж чаддаг болно.	Орчин үеийн этник хамтлагуудын уран бүтээлээс сонсоод бүтээлдээ авч ашигласан уламжлалт төрлүүдийг ялгаж чаддаг.
		Орчин үеийн этник хамтлагуудын уран бүтээлээс сонсоод бүтээлдээ авч ашигласан хөгжмийн зэмсгүүдийн өнгө дуурьсал, хөгжимдөх арга барилыг тайлбарладаг.
2	Сурагч монгол ардын урлагийн төрлүүдээс сонгон орчин үеийн хөгжмийн урлагтай хослуулсан зохиомж хийж чаддаг болно.	Монгол ардын урлагийн төрлүүдийг орчин үеийн хөгжмийн урлагийн төрлүүдтэй хослуулан янз бүрийн аргаар зохиомж хийж чаддаг.

2.5.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Орчин үеийн этник хамтлагуудын уран бүтээлээс сонсоод бүтээлдээ авч ашигласан уламжлалт төрлүүдийг ялгаж чаддаг.	Орчин үеийн этник хамтлагуудын уран бүтээлээс сонсоод бүтээлдээ авч ашигласан уламжлалт төрлүүдийг нэрлэдэг.	Орчин үеийн этник хамтлагуудын уран бүтээлдээ авч ашигласан уламжлалт төрлүүдийн үүргийг тайлбарладаг.	Орчин үеийн этник хамтлагуудын уран бүтээлийн найруулгад анализ хийж өөрийн санаа бодлыг илэрхийлдэг.	Орчин үеийн этник хамтлагуудын уран бүтээлийн найруулгаар жишээлэн өөрийн бүтээлийн санаа гаргадаг.
Орчин үеийн этник хамтлагуудын уран бүтээлээс сонсоод бүтээлдээ авч ашигласан хөгжмийн зэмсгүүдийн өнгө дуурьсал, хөгжимдөх арга барилыг тайлбарладаг.	Этник хамтлагуудын уран бүтээлдээ ашигласан хөгжмийн зэмсгүүдийг нэрлэдэг.	Этник хамтлагуудын бүтээлээс сонсоод хөгжмийн зэмсгүүдийн өнгө дуурьслыг ялгаж тодорхойлдог.	Этник хамтлагуудын хөгжимдөх арга барилыг тодорхой хөгжмийн зэмсгээр жишээлэн тайлбарладаг.	Этник хамтлагуудын бүтээлдээ ашигласан хөгжмийн зэмсгүүдийг өөр зэмсгээр зохиомжлох талаар шинэ санаа дэвшүүлж, гүйцэтгэдэг.
Монгол ардын урлагийн төрлүүдийг орчин үеийн хөгжмийн урлагийн төрлүүдтэй хослуулан янз бүрийн аргаар зохиомж хийж чаддаг.	Монгол ардын урлагийн төрлүүдийг орчин үеийн урлагийн төрлүүдтэй харьцуулан тайлбарладаг.	Монгол ардын урлагийг орчин үеийн хөгжмийн урлагтай хослуулах аргаа төлөвлөж чаддаг.	Монгол ардын урлагийг орчин үеийн хөгжмийн урлагтай өөрийн сонгосон аргаар хослуулан зохиомж хийж чаддаг.	Монгол ардын урлагийг орчин үеийн хөгжмийн урлагтай хослуулан зохиомжилсоноо гүйцэтгэж харуулдаг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. VIII АНГИ

3. VIII АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

3.1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 1. ДУУРЬ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Сураалцахуйн зорилт	Сураалцахуйн үр дүн
8.1а. Сонгодог хөгжмийн төрлүүд, илэрхийллийн арга хэлбэр, онцлогийг тодорхойлох	Сурагч хөгжмийн бүтээлийг үзэж сонсоод сонгодог урлагийн төрлүүдийг ялгадаг болно.
8.1б. Дуурийн үүсэл хөгжил, төрөл хэлбэр, бүтэц, онцлогийг тайлбарлах	Сурагч дуурийн болон дуулаачийн төрөл, хэлбэр, бүтэц, үүргийг ялган тодорхойлдог болно.
8.1в. Дуурь дахь дуулаачийн төрлүүдийг сонсоод, ялган таних, үүргийг тайлбарлах	Сурагч дуурийн шилдэг бүтээлүүдээс үзэж сонсоод урлагийн төрлүүдийн уялдаа холбоог тайлбарладаг болно.
8.1г. Урлагийн төрлүүдийн харилцан уялдаа холбоог бүтээлийн жишээгээр харуулах	Дуурийн шилдэг бүтээлээс үзэж сонсоод гол сэдэв аялгууг аялж чаддаг болно.
8.1д. Дуурийн уран бүтээлийн шилдэг үзүүлбэрээс сонсож тодорхойлох, тайлбарлах	
8.1е. Аялгууны шинж төрх, хөгжмийн хэл, сэтгэл хөдлөлийн илрэлийг хөдөлгөөнөөр хэрхэн илэрхийлснийг шилдэг бүтээлийн жишээн дээр тайлбарлах	

3.1.1. Сураалцахуйн үр дүнгийн шалгуур

№	Сураалцахуйн үр дүн	Сураалцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч хөгжмийн бүтээлийг үзэж сонсоод сонгодог урлагийн төрлүүдийг ялгадаг болно.	Хөгжмийн бүтээлүүдийг үзэж сонсоод сонгодог урлагийн төрлүүдийн онцлог, илэрхийллийн арга барилаар нь ялгадаг.
2	Сурагч дуурийн болон дуулаачийн төрөл, хэлбэр, бүтэц, үүргийг ялган тодорхойлдог болно.	Дуурийн төрөл, хэлбэр бүтцийг тайлбарладаг. Дуурь дахь дуулаачийн урлагийн төрлүүдийг ялган таньж, хэлбэр, бүтэц, үүргийг тодорхойлдог.
3	Сурагч дуурийн шилдэг бүтээлүүдээс үзэж сонсоод урлагийн төрлүүдийн уялдаа холбоог тайлбарладаг болно.	Дуурийн шилдэг бүтээлүүдээс үзэж сонсоод урлагийн төрлүүдийн уялдааг бүтээлийн жишээгээр тайлбарладаг.
4	Дуурийн шилдэг бүтээлээс үзэж сонсоод гол сэдэв аялгууг аялж чаддаг болно.	Дуурийн шилдэг бүтээлүүдээс үзээд аялгууны шинж төрхийг дүрүүдийн сэтгэл хөдлөлтэй холбон ойлгож, гол сэдэв аялгууг аялдаг.

3.1.2. Гүйцэтгэлийн түвшин

Сураалцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Хөгжмийн бүтээлүүдийг үзэж сонсоод сонгодог урлагийн төрлүүдийг онцлог, илэрхийллийн арга барилаар нь ялгадаг.	Сонгодог хөгжмийн бүтээлүүдийг үзэж сонсоод төрлүүдийг ялган нэрлэдэг.	Сонгодог хөгжмийн бүтээлүүдийг үзэж сонсоод онцлогийг тайлбарладаг.	Сонгодог хөгжмийн бүтээлүүдийг үзэж сонсоод илэрхийллийн арга барилаар нь харьцуулдаг.	Сонгодог урлагийн талаар мэдээлэл цуглуулж, бусдадаа танилцуулдаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Дуурийн төрөл, хэлбэр бүтцийг тайлбарладаг.	Дуурийн үүсэл хөгжлийн талаар мэдээлэл цуглуулж тэмдэглэдэг.	Дуурийн шилдэг бүтээлээс үзээд төрлийг тодорхойлдог.	Дуурийн шилдэг бүтээлээс үзээд хэлбэрийг тодорхойлж тайлбарладаг.	Дуурийн шилдэг бүтээлээс үзээд бүтцийг жишээгээр тайлбарладаг.
Дуурь дахь дуулаачийн урлагийн төрлүүдийг ялган таньж, хэлбэр, бүтэц, үүргийг тодорхойлдог.	Дуурь дахь дуулаачийн төрлүүдийг сонсоод таньж нэрлэдэг.	Дуурь дахь дуулаачийн урлагийн төрлүүдийн хэлбэрийг тодорхойлдог.	Дуурь дахь дуулаачийн урлагийн төрлүүдийн бүтцийг тодорхойлдог.	Дуурь дахь дуулаачийн бүтээлийн үүргийг харьцуулан тайлбарладаг.
Дуурийн шилдэг бүтээлүүдээс үзэж сонсоод урлагийн төрлүүдийн уялдааг бүтээлийн жишээгээр тайлбарладаг.	Дуурийн шилдэг бүтээлүүдээс үзээд өөрийн мэдэх урлагийн төрлүүдийг нэрлэдэг.	Урлагийн бусад төрлүүдийн дуурьт гүйцэтгэх үүргийг тайлбарладаг.	Дуурийн шилдэг бүтээлүүдээс үзээд урлагийн төрлүүдийн холбоо хамаарлыг зураглалаар илэрхийлдэг.	Дуурийн шилдэг бүтээлүүдээс үзээд нийгэм, цаг үетэй холбон, шүүмжлэлт сэтгэлгээгээр тайлбарладаг.
Дуурийн шилдэг бүтээлүүдээс үзээд аялгууны шинж төрхийг дүрүүдийн сэтгэл хөдлөлтэй холбон ойлгож, гол сэдэв аялгууг аялдаг.	Дуурийн шилдэг бүтээлүүдээс үзээд утга агуулгын тодорхойлдог.	Дуурийн шилдэг бүтээлүүдээс үзээд аялгууны шинж төрх, дүр дүрслэлийг зурагладаг.	Дуурийн гол болон туслах дүрийн аялгууны шинж төрхийг сэтгэл хөдлөлтэй нь холбон тайлбарладаг.	Дуурийн шилдэг бүтээлүүдийг үзэж сонсдог, гол сэдэв аялгууг аялж чаддаг.

3.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 2. СИМФОНИ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
8.2а. Симфони хөгжмийн үүсэл хөгжил, төрөл хэлбэр, бүтэц онцлогийг тайлбарлах	Сурагч симфони бүтээл, сонгодог хөгжмийг сонсоод төрөл, хэлбэр, бүтцийг ялган тодорхойлдог болно.
8.2б. Суут хөгжмийн зохиолчдын шилдэг бүтээлээс сонсоод хөгжмийн зэмсгүүдийг төрөл ангилал, гүйцэтгэх үүргээр нь ялган тодорхойлох, ардын хөгжмийн зэмсгүүдтэй харьцуулах	Сурагч сонгодог бүтээлээс хөгжмийн зэмсгүүдийн эгшиглэгээний (тембр) онцлогийг ялгаж сонсдог болно.
8.2в. Өөрийн сонсох дуртай сонгодог хөгжмийн бүтээлд сонсголын ажиглалт хийж, сэтгэгдлээ илэрхийлэх, онцолсон зүйлээ тэмдэглэх, тайлбарлах	Сурагч шилдэг симфони бүтээлээс сонсоод сонсголын ажиглалт хийдэг болно.
	Сурагч хөгжим сонсох, дуулах хэрэгцээндээ симфони бүтээлийн сэдэв аялгууг ашиглан зохиомж хийж чаддаг.

3.2.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч симфони бүтээл, сонгодог хөгжмийг сонсоод төрөл, хэлбэр, бүтцийг ялган тодорхойлдог болно.	Симфони хөгжмийн бүтээлийг сонсоод анги тус бүрийг ялган тодорхойлдог. Симфони хөгжим болон дуурийн урлагийг харьцуулан илэрхийллийн аргыг тайлбарладаг.
2	Сурагч сонгодог бүтээлээс хөгжмийн зэмсгүүдийн эгшиглэгээний (тембр) онцлогийг ялгаж сонсдог болно.	Симфони хөгжмийн зэмсгүүдийг харьцуулаад эгшиглэгээний онцлогийг тайлбарладаг.

3	Сурагч симфони бүтээлээс сонсоод сонсголын ажиглалт хийдэг болно.	Симфони бүтээлээс сонсоод аялгууны шинж төрх, хурд хүч, дүрслэл зэргийг тодорхойлж сэтгэгдлээ илэрхийлдэг.
4	Сурагч хөгжим сонсох, дуулах хэрэгцээндээ симфони бүтээлийн сэдэв аялгууг ашиглан зохиомж хийж чаддаг.	Симфони бүтээлийн сэдэв аялгууг ашиглан дижитал технологиор зохиомжилдог.

3.2.2. Гүйцэтгэлийн түвшин

СИМФОНИ. Симфони хөгжмийн үүсэл хөгжлийг тайлбарлан бичдэг.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Симфони хөгжмийн бүтээлээс сонсоод анги тус бүрийг ялган тодорхойлдог.	Симфони хөгжмийн шилдэг бүтээлээс сонсоод анги тус бүрийг таньж нэрлэдэг.	Симфони хөгжмийн анги тус бүрийн аялгууны шинж төрхийг тодорхойлдог.	Симфони хөгжмийн анги тус бүрийн агуулга, дүр дүрслэлийг тодорхойлдог.	Симфони хөгжмийн шилдэг бүтээлээс сонсоод анги тус бүрийн онцлогийг тайлбарладаг.
Симфони хөгжим болон дуурийн урлагийг харьцуулан илэрхийллийн аргыг тайлбарладаг.	Симфони болон дуурийн хөгжмийг харьцуулан тайлбарладаг.	Симфони хөгжмийн болон дуурийн илэрхийллийн аргыг тайлбарладаг.	Симфони хөгжим болон дуурийн урлагийн тухай мэдрэмж, санаагаа янз бүрийн хэлбэрээр илэрхийлдэг.	Симфони хөгжим болон дуурийн урлагийг харьцуулан оюуны зураглалаар зурагладаг.
Симфони хөгжмийн зэмсгүүдийг харьцуулаад эгшиглэгээний онцлогийг тайлбарладаг.	Симфони хөгжмийн зэмсгүүдийг гүйцэтгэх үүргээр нь ангилдаг.	Симфони хөгжмийн зэмсгүүдийн эгшиглэлтэд харьцуулалт хийж тус бүрийн үүргийг тайлбарладаг.	Симфони хөгжмийн зэмсгүүдийн эгшиглэлтийг ардын хөгжмийн зэмсгийн эгшиглэлтэй харьцуулж дүгнэлт гаргадаг.	Симфони хөгжмийн зэмсгүүдийн эгшиглэгээний онцлогийг зохиолын утга санаатай холбон тайлбарладаг.
Симфони бүтээлээс сонсоод аялгууны шинж төрх, хурд хүч, дүрслэлийг тодорхойлж сэтгэгдлээ илэрхийлдэг.	Симфони бүтээлээс сонсоод аялгууны шинж төрхийг тодорхойлдог.	Хөгжмийн хэлний хэрэглүүр ашиглан симфони бүтээлийг тайлбарладаг.	Симфони бүтээлийг сонсоод төрсөн сэтгэгдэлээ янз бүрийн аргаар илэрхийлдэг.	Өөрийн сонсох дуртай сонгодог хөгжмийн бүтээлд сонсголын ажиглалт хийж, сэтгэгдлээ янз бүрийн хэлбэрээр илэрхийлдэг.
Симфони бүтээлийн сэдэв аялгууг дижитал технологиор зохиомжилдог.	Симфони бүтээлийг сонсоод сэдэв аялгуунаас онцолсон зүйлээ тэмдэглэдэг.	Сэдэв аялгууг зохиомжлох техник хэрэгслээ сонгож чаддаг.	Сонсох дуртай сонгодог хөгжмийн бүтээлээс төрсөн сэтгэгдлээ техник хэрэгсэл ашиглан илэрхийлдэг.	Симфони бүтээлийн сэдэв аялгууг дижитал технологиор зохиомжлох оролдого хийдэг.

3.3. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 3. БҮЖГЭН ЖҮЖИГ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
8.3а. Бүжгэн жүжгийн үүсэл хөгжил, илэрхийллийн арга хэлбэр, бүжигт хөгжмийн гүйцэтгэх үүргийн талаар тайлбарлах	Сурагч сонгодог бүжгийн урлагийн илэрхийллийн онцлогийг тайлбарладаг болно.
8.3б. Цэнгээнт болон чөлөөт бүжгийн энгийн элементүүдэд тулгуурлан өөрийн бүтээлийг хийж харуулах	Сурагч шилдэг бүтээлүүдийн агуулга дүрийг бүжгийн хэл болон хөгжимтэй холбон тайлбарладаг болно.
8.3в. Бүжгийн урлагийн дүрслэл илэрхийллийн өвөрмөц арга, утга агуулга, дүр дүрслэлийг хөдөлгөөнтэй холбон тайлбарлах, бүжгийн хөгжмийн аялгууны шинж төрх, хурд, хүчийг тодорхойлох	Сурагч сонгодог бүжгийн энгийн элемент оролцуулан өөрийн санаа, мэдрэмжийг илэрхийлсэн чөлөөт болон цэнгээнт бүжиг зохиомжилж уран сайхны хэрэгцээгээ хангах чадвартай болно.

3.3.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч сонгодог бүжгийн урлагийн илэрхийллийн онцлогийг тайлбарладаг болно.	Бүжгэн жүжгийн илэрхийллийн арга хэлбэр, бүжигт хөгжмийн гүйцэтгэх үүргийн талаар тайлбарладаг.
2	Сурагч шилдэг бүтээлүүдээс үзэж агуулга дүрийг бүжгийн хэл болон хөгжимтэй холбон тайлбарладаг болно.	Бүжгэн жүжгийн бүтээлүүдээс үзээд агуулга, дүр дүрслэлийг хөгжим, хөдөлгөөнтэй холбон жишээгээр тайлбарладаг.
3	Сурагч сонгодог бүжгийн энгийн элемент оролцуулан өөрийн санаа, мэдрэмжийг илэрхийлсэн чөлөөт болон цэнгээнт бүжиг зохиомжилж уран сайхны хэрэгцээгээ хангах чадвартай болно.	Сонгодог бүжгийн энгийн элемент оролцуулан өөрийн санаа, мэдрэмжийг илэрхийлсэн чөлөөт болон цэнгээнт бүжиг зохиомжилдог.

3.3.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Бүжгэн жүжгийн илэрхийллийн арга хэлбэр, бүжигт хөгжмийн гүйцэтгэх үүргийн талаар тайлбарладаг.	Сонгодог бүжгэн жүжгийн илэрхийллийн аргыг танилцуулдаг.	Сонгодог бүжгэн жүжгийг ардын бүжигтэй харьцуулдаг.	Бүжгэн жүжгийн бүтээлүүдийг хөгжимтэй хөгжимгүй үзээд ялгааг тодруулдаг.	Сонгодог бүжигт хөгжмийн гүйцэтгэх үүргийг жишээгээр тайлбарладаг.
Бүжгэн жүжгийн бүтээлүүдээс үзээд агуулга, дүр дүрслэлийг хөгжим, хөдөлгөөнтэй холбон жишээгээр тайлбарладаг.	Бүжгэн жүжгийн бүтээлүүдээс үзээд дүрүүдийн онцлогийг тайлбарладаг.	Бүжгэн жүжгийн бүтээлийн агуулга, дүр дүрслэлийг хөгжмийн хэлээр хэрхэн илэрхийлснийг тайлбарладаг.	Бүжгэн жүжгийн бүтээлийн агуулга, дүр дүрслэлийг бүжгийн хэлээр хэрхэн илэрхийлснийг тайлбарладаг.	Бүжгэн жүжгийн бүтээлүүдээс сонгон өөрийн мэдрэмж, сэтгэгдэлээр баяжуулан зохиомжилдог.
Сонгодог бүжгийн энгийн элемент оролцуулан өөрийн санаа, мэдрэмжийг илэрхийлсэн чөлөөт болон цэнгээнт бүжиг зохиомжилдог	Сонгодог бүжгийн энгийн элементүүдийг нэрлэж тайлбарладаг.	Бүжиглэх төрлөө сонгож чаддаг.	Сонгосон төрөлдөө тохирох хөгжмийг сонгож чаддаг.	Өөрийн санаа, мэдрэмжийг илэрхийлсэн чөлөөт болон цэнгээнт бүжиг зохиомжлон бүжиглэж үзүүлдэг.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. IX АНГИ

4. IX АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

4.1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 1. ОРЧИН ҮЕИЙН ХӨГЖМИЙН УРЛАГ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
9.1а. Орчин үеийн хөгжмийн урсгал чиглэлүүд, тэдгээрийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрүүдийг ялган таних, тайлбарлах	Сурагч орчин үеийн хөгжмөөс сонсоод урсгал чиглэлүүдийн онцлогийг тайлбарлаж чаддаг болно.
9.1б. Импрессионист, экспрессионист урсгалын онцлогийг хөгжим-уран зураг-уран зохиолын бүтээлийн жишээн дээр харьцуулан тайлбарлах, сонсож таних, тодорхойлох	Сурагч орчин үеийн хөгжмийн урлагийн шинэчлэлт өөрчлөлтийг жишээгээр харуулдаг.
9.1в. Авангард урлаг, бүтээлч илэрхийллийн арга барилууд, тэдгээрийн онцлогийг тайлбарлах, жишээгээр харуулах	Сурагч уран бүтээлүүдээс төрсөн сэтгэгдлээ янз бүрийн аргаар илэрхийлж чаддаг болно.
9.1г. Найрал хөгжмийн зэмсгийн дуурьслын хүч, хэмнэл, аялгууны шинж төрхийг сонсож тодорхойлох	Сурагч янз бүрийн аппликейшн, эффект ашиглан тодорхой сэдэвт зохиомж хийж чаддаг болно.
9.1д. Орчин үеийн хөгжмийн урлагийн төрөл, хэлбэр, илэрхийллийн арга барилд гарсан шинэчлэлт өөрчлөлт, тэдгээрийн холбоо хамаарлыг жишээгээр тайлбарлах, харуулах	
9.1е. Зураг болон хөгжим, шүлгээс төрсөн сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэх, хөгжмийн илэрхийлэмжийг өөрийн санаагаар баяжуулах, тайлбарлах	

4.1.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч орчин үеийн хөгжмөөс сонсоод урсгал чиглэлүүдийн онцлогийг тайлбарлаж чаддаг болно.	Орчин үеийн хөгжмийн бүтээлээс сонсоод, урсгал чиглэлүүдийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрүүдийн ялгааг тайлбарладаг.
		Орчин үеийн хөгжмийн бүтээлээс сонсоод найрал хөгжмийн зэмсгийн дуурьслын хүч, хэмнэл, аялгууны шинж төрхийг тодорхойлдог.
2	Сурагч орчин үеийн хөгжмийн урлагийн шинэчлэлт өөрчлөлтийг жишээгээр харуулдаг.	Орчин үеийн хөгжмийн урлагийн төрөл хэлбэр, илэрхийллийн арга барилд гарсан шинэчлэлт өөрчлөлтүүдийг жишээгээр тайлбарладаг.
3	Сурагч уран бүтээлүүдээс төрсөн сэтгэгдлээ янз бүрийн аргаар илэрхийлж чаддаг болно.	Орчин үеийн хөгжмийн урсгалын онцлог ялгааг хөгжим, уран зураг, уран зохиолын жишээн дээр тайлбарладаг.
4	Сурагч янз бүрийн аппликейшн, эффект ашиглан тодорхой сэдэвт зохиомж хийж чаддаг болно.	Бодит хөгжим бүтээсэн аргаар янз бүрийн аппликейшн, эффект, дижитал төхөөрөмж ашиглан тодорхой сэдэвт зохиомж хийж чаддаг.

4.1.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Орчин үеийн хөгжмийн бүтээлээс сонсоод, урсгал чиглэлүүдийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрүүдийн ялгааг тайлбарладаг.	Орчин үеийн хөгжмийн бүтээлээс сонсоод урсгал чиглэлүүдийг тодорхойлж нэрлэдэг.	Орчин үеийн хөгжмийн бүтээлээс сонсоод, урсгал чиглэлүүдийн гол онцлогийг тодруулдаг.	Орчин үеийн хөгжмийн бүтээлээс сонсоод, илэрхийллийн арга хэлбэрүүдийн ялгааг тайлбарладаг.	Орчин үеийн хөгжмийн урсгал чиглэлүүдийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрүүдийг зурагладаг. (mapping)
Орчин үеийн хөгжмийн бүтээлээс сонсоод найрал хөгжмийн зэмсгийн дуурьслын хүч, хэмнэл, аялгууны шинж төрхийг тодорхойлдог.	Орчин үеийн хөгжмийн бүтээлээс сонсоод найрал хөгжмийн бүрэлдэхүүн дэх зэмсгүүдийг нэрлэдэг.	Орчин үеийн хөгжмийн бүтээлээс сонсоод айзам хэмжээ, аялгууны шинж төрхийг тодорхойлдог.	Орчин үеийн хөгжмийн бүтээлээс сонсоод найрал хөгжмийн зэмсгийн дуурьслын хүчийг жишээн дээр тайлбарладаг.	Орчин үеийн хөгжмийн хэмнэл, аялгууны шинж төрх, хөгжмийн зэмсгийн дуурьсалд тулгуурлан өөрийн бүтээлийг зохиомжлон бүтээдэг.
Орчин үеийн хөгжмийн урлагийн төрөл хэлбэр, илэрхийллийн арга барилд гарсан шинэчлэлт өөрчлөлтүүдийг жишээгээр тайлбарладаг.	Орчин үеийн хөгжмийн бүтээлийн төрөл хэлбэрийг таньж тодорхойлдог.	Орчин үеийн хөгжмийн урлагийн илэрхийллийн арга барилд гарсан өөрчлөлтүүдийг тайлбарладаг.	Орчин үеийн хөгжмийн урлагт гарсан шинэчлэлт өөрчлөлтүүдийг нийгэм цаг үетэй холбон ойлгож тайлбарладаг.	Орчин үеийн хөгжмийн бүтээлийн илэрхийлэх арга хэлбэрт гарсан шинэчлэлт өөрчлөлтийг уран бүтээлийн жишээн дээр харьцуулан дүгнэлт гаргадаг.
Орчин үеийн хөгжмийн урсгалын онцлог ялгааг хөгжим, уран зураг, уран зохиолын жишээн дээр тайлбарладаг.	Орчин үеийн хөгжмийн урсгалын онцлог, ялгааг уран зохиолтой холбон жишээгээр тайлбарладаг.	Орчин үеийн хөгжмийн урсгалын онцлог, ялгааг уран зурагтай холбон жишээгээр тайлбарладаг.	Орчин үеийн хөгжим, уран зураг, шүлгээс төрсөн сэтгэгдлээ зураг, бичвэрээр илэрхийлж тайлбарладаг.	Орчин үеийн хөгжим, уран зураг, шүлгээс төрсөн сэтгэгдлээ өөрийн санаагаар баяжуулж бусдад танилцуулдаг.
Бодит хөгжим бүтээсэн аргаар янз бүрийн аппликейшн, дижитал төхөөрөмж ашиглан тодорхой сэдэвт зохиомж хийж чаддаг.	Тодорхой сэдэвт зохиомж хийх аппликейшн, дижитал төхөөрөмжөө сонгож чаддаг.	Янз бүрийн аппликейшн, дижитал төхөөрөмж ашиглан хийх зохиомжоо төлөвлөдөг.	Янз бүрийн аппликейшн, дижитал төхөөрөмж ашиглан тодорхой сэдэвт зохиомж хийж чаддаг.	Янз бүрийн аппликейшн, дижитал төхөөрөмж ашиглан хийсэн зохиомжоо гүйцэтгэж харуулдаг.

4.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 2. МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ХӨГЖМИЙН УРЛАГ,
СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
9.2а. Монголын орчин үеийн хөгжмийн үүсэл хөгжил, гол төлөөлөгчид, шилдэг бүтээлийн талаар жишээгээр тайлбарлах	Сурагч монголын орчин үеийн хөгжмийн урлагийн талаар тайлбарлаж чаддаг болно.
9.2б. Монголын орчин үеийн симфони, дан хөгжмийн бүтээлээс сонсоод хөгжмийн зэмсэг, хэмнэлийн илэрхийлэл, дуурьсал тэдгээрт гарсан өөрчлөлт, эгшиглэх онцлогийг тайлбарлах	Сурагч монголын орчин үеийн симфони, дан хөгжим, театрын бүтээлүүдээс сонсоод өөрчлөлт, шинэчлэлтийг тайлбарладаг болно.
9.2в. Монголын орчин үеийн хөгжмийн театрын бүтээлийн санаа, илэрхийллийн арга барил, онцлогийг тайлбарлах, жишээгээр харуулах	Сурагч янз бүрийн дижитал төхөөрөмж ашиглан сонсох дуртай дуу, хөгжмийн зохиомж хийж чаддаг болно.

4.2.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч монголын орчин үеийн хөгжмийн урлагийн тухай мэдээлэлтэй болно.	Монголын орчин үеийн хөгжмийн шилдэг бүтээлүүдийг жишээгээр тайлбарладаг.
2	Сурагч монголын орчин үеийн симфони, дан хөгжим, театрын бүтээлүүдээс сонсоод өөрчлөлт, шинэчлэлтийг тайлбарлаж чаддаг болно.	Монголын орчин үеийн симфони, дан хөгжмийн бүтээлээс сонсоод, хөгжмийн зэмсэг, хэмнэл, дуурьсалд гарсан өөрчлөлт, эгшиглэх онцлогийг жишээгээр тайлбарладаг. Монголын орчин үеийн театрын бүтээлийн санаа, илэрхийллийн арга барил, онцлогийг жишээгээр тайлбарладаг.
3	Сурагч янз бүрийн дижитал төхөөрөмж ашиглан сонсох дуртай дуу, хөгжмийн зохиомж хийж чаддаг болно.	Монголын орчин үеийн хөгжмийн бүтээлүүдээс ашиглан янз бүрийн дижитал төхөөрөмжөөр өөрийн дуртай дуу, хөгжмийн зохиомж хийж чаддаг.

4.2.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Монголын орчин үеийн хөгжмийн шилдэг бүтээлүүдийг жишээгээр тайлбарладаг.	Монголын орчин үеийн хөгжмийн бүтээлүүдээс нэрлэдэг.	Монголын орчин үеийн хөгжмийн гол төлөөлөгчдийг бүтээлээр нь жишээлж тайлбарладаг.	Монголын орчин үеийн хөгжмийн шилдэг бүтээлүүдийг гадаадын бүтээлүүдтэй харьцуулан дүгнэлт гаргадаг.	Монголын орчин үеийн хөгжмийн талаар мэдээлэл цуглуулж бусдад PPT-оор танилцуулдаг.
Монголын орчин үеийн симфони, дан хөгжмийн бүтээлээс сонсоод, хөгжмийн зэмсэг, хэмнэл, дуурьсалд гарсан өөрчлөлт, эгшиглэх онцлогийг жишээгээр тайлбарладаг.	Монголын симфони, дан хөгжмийн бүтээлээс сонсоод, хөгжмийн зэмсгүүдийг нэрлэдэг.	Монголын симфони, дан хөгжмийн бүтээлээс сонсоод, эгшиглэх онцлогийг тайлбарладаг.	Монголын симфони, дан хөгжмийн бүтээлээс сонсоод эгшиглэх онцлог, хэмнэл, дуурьсалд гарсан өөрчлөлтийг жишээгээр тайлбарладаг.	Монголын симфони, дан хөгжмийн бүтээлийг сонгодог симфони хөгжимтэй харьцуулан хэмнэл, дуурьсал, эгшиглэх онцлогийг хооронд нь харьцуулан дүгнэлт гаргадаг.

Монголын орчин үеийн театрын бүтээлийн санаа, илэрхийллийн арга барил, онцлогийг жишээгээр тайлбарладаг.	Монголын орчин үеийн театрын бүтээлүүдээс нэрлэдэг.	Монголын орчин үеийн театрын бүтээлийг сэдэв агуулгаар нь төрөлжүүлэн ангилдаг.	Монголын орчин үеийн театрын бүтээлийн илэрхийллийн арга барил, онцлогийн холбоо хамаарлыг тодорхойлдог.	Монголын орчин үеийн театрын бүтээлийн санаа, илэрхийллийн арга барил, онцлогийг харьцуулан оюуны зураглалаар тайлбарладаг.
Монголын орчин үеийн хөгжмийн бүтээлүүдээс ашиглан янз бүрийн дижитал төхөөрөмжөөр сонсох дуртай дуу, хөгжмийн зохиомж хийж чаддаг.	Хөгжмийн зохиомж хийхдээ орчин үеийн хөгжмийн бүтээлүүдээс сонголт хийж чаддаг.	Хөгжмийн зохиомж хийх аппликейшн, дижитал төхөөрөмжөө сонгож төлөвлөдөг.	Сонсох дуртай дуу, хөгжмийн зохиомжоо янз бүрийн аппликейшн, дижитал төхөөрөмж ашиглан хийж чаддаг.	Сонсох дуртай дуу, хөгжмийн зохиомжоо янз бүрийн хэлбэрээр бусдад танилцуулдаг.

4.3. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 3. ЭСТРАД ХӨГЖИМ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
9.3а. Эстрад (джаз, рок, поп,) урлагийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрийг сонсож тодорхойлох, тайлбарлах	Сурагч эстрад урлагийн бүтээлүүдийг сонсоод ялгадаг болно.
9.3б. Эстрад хөгжмийн бүтээлийг сонсоод хэмнэл, дуурьсал, зэмсгүүдийн гүйцэтгэх үүргийг тайлбарлах	Сурагч эстрад хөгжмийн бүтээлд гарсан өөрчлөлт шинэчлэлтийг тайлбарлаж чаддаг болно.
9.3в. Эстрад хөгжмийн урлагт гарсан шинэчлэлт өөрчлөлтийг жишээгээр тайлбарлах, үзүүлэх	Сурагч өөрийн сонирхсон эстрад хөгжмийн бүтээлээс дуулж, хөгжимддөг.

4.3.1. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч эстрад урлагийн бүтээлүүдийг сонсоод ялгадаг болно.	Эстрад урлагийн бүтээлүүдийг сонсоод төрөл тус бүрийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрээр нь ялгаж тайлбарладаг.
2	Сурагч эстрад хөгжмийн бүтээлийг сонсоод гарсан өөрчлөлт шинэчлэлтийг тайлбарлаж чаддаг болно.	Эстрад хөгжмийн бүтээлийг сонсоод хэмнэл, дуурьсал, хөгжмийн зэмсгүүдийн гүйцэтгэх үүргийг тайлбарладаг. Эстрад хөгжмийн урлагт гарсан шинэчлэлт өөрчлөлтийг жишээгээр тайлбарладаг.
3	Сурагч өөрийн сонирхсон эстрад хөгжмийн бүтээлээс дуулж, хөгжимдөж чаддаг.	Эстрад хөгжмийн бүтээлүүдээс сонгон өөрийн санаагаар баяжуулан сэтгэл хөдлөлөө илэрхийлэн дуулж, хөгжимдөж чаддаг.

4.3.2. Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Эстрад урлагийн бүтээлүүдийг сонсоод төрөл тус бүрийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрийг тайлбарладаг.	Эстрад урлагийн бүтээлүүдийг сонсоод урсгал чиглэлийг нэрлэдэг.	Эстрад урлагийн бүтээлүүдийг сонсоод онцлогийг тайлбарладаг.	Эстрад урлагийн бүтээлүүдийг сонсоод илэрхийллийн арга хэлбэрийг жишээгээр тайлбарладаг.	Эстрад урлагийн бүтээлүүдийн төрөл тус бүрийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрийг харьцуулж тайлбарладаг.
Эстрад хөгжмийн бүтээлийг сонсоод хэмнэл, дуурьсал, хөгжмийн зэмсгүүдийн гүйцэтгэх үүргийг тайлбарладаг.	Эстрад хөгжмийн бүтээлийг сонсоод хөгжмийн зэмсгүүдийг нэрлэж, дуурьслаар нь бүлэглэдэг.	Эстрад хөгжмийн бүтээлд хэмнэл дуурьслын гүйцэтгэх үүргийг тодруулж тайлбарладаг.	Эстрад хөгжмийн бүтээлийн хэмнэл, зэмсгүүдийн хамаарал, нийцлийг тайлбарладаг.	Эстрад хөгжмийн бүтээлийг сонсоод өөр урсгал чиглэлийн бүтээлүүдтэй харьцуулан анализ хийдэг.
Эстрад хөгжмийн урлагт гарсан шинэчлэлт өөрчлөлтийг жишээгээр тайлбарладаг.	Эстрад хөгжмийн урлагийн төрлүүдийг зураглаж үзүүлдэг.	Эстрад хөгжмийн урлагт гарсан өөрчлөлтүүдийг нийгэм цаг үетэй холбон тайлбарладаг.	Эстрад хөгжмийн урлагт гарсан өөрчлөлтийг уран бүтээлээр төлөөлүүлэн тайлбарладаг.	Эстрад хөгжмийн бүтээлийн илэрхийлэх арга хэлбэрт гарсан өөрчлөлтийг түүхэн цаг үетэй холбон харьцуулж дүгнэлт гаргадаг.
Эстрад хөгжмийн бүтээлүүдээс сонгон өөрийн санаагаар баяжуулан сэтгэл хөдлөлөө илэрхийлэн дуулж, хөгжимдөж чаддаг.	Эстрад хөгжмийн бүтээлүүдээс сонгон дуулж чаддаг.	Эстрад хөгжмийн бүтээлүүдээс сонгон хөгжимдөж чаддаг.	Эстрад хөгжмийн бүтээлүүдээс сонгон өөрийн санаагаар баяжуулан дуулж, хөгжимдөж үзүүлдэг.	Өөрийн санаагаар баяжуулан дуулж, хөгжимдөхдөө сэтгэл хөдлөлөө илэрхийлж чаддаг.



“ЕБС-ийн Хөгжмийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”-ыг боловсруулсан ажлын хэсэг:

Х.Энхжаргал	Боловсролын хүрээлэн, БХСС, ЭША, магистр
Ц.Булгамаа	Орхон аймгийн ерөнхий боловсролын 20 дугаар сургуулийн хөгжмийн багш
Ж.Ууганцэцэг	“Шинэ үе” сургуулийн хөгжмийн багш, магистр

Хөндлөнгийн шинжээч:

Ч.Оюунбилэг	СУИС-ийн ХУС-ийн БУБ-ийн тэнхимийн багш, дэд профессор
-------------	--

Техникийн редактор:

Г.Дэлгэрмаа	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, доктор (Ph.D)
-------------	--

Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:

Э.Сансартуяа	“Хас дизайн пресс” ХХК-ийн дизайнер
Л.Алтансүх	Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо
Энхтайваны өргөн чөлөө, Арслантай гүүр
“ОЮУНЫ УНДРАА” группийн байр

Утас: 70119498, 70118485
И-мэйл: info@eecs.mn